

ТӨСЛИЙН ЗАХИР



Ш.ЦЭРЭНДУЛАМ

2022 оны 4 дугаар сарын 15 өдөр

Басгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

(2022 оны 4 дугаар улирлын байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Төслийн нэр: Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь Төслийн код: FP141 Баталсан огноо: 2021 оны 03 сарын 31
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Уур амьсгалын ногоон сан (УАНС)-ын буцалтгүй тусламж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: <ul style="list-style-type: none">- Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)- Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) Хэрэгжих хугацаа: 7 жил
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилго: Байгалийн нөөцөөс хамааралтай хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг дээшлүүлэхэд оршино. Бүрэлдэхүүн хэсэг 1: Үндэсний болон бүс нутгийн түвшинд газар, усны ашиглалтыг уур амьсгалын мэдээлэлд тулгуурлан төлөвлөж, хэрэглэдэг болох Бүрэлдэхүүн хэсэг 2: Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ус, хөрсний менежментийн арга ажиллагааг өргөн хүрээнд нэвтрүүлэн байгалийн нөөцийн менежментэд малчдын оролцоог нэмэгдүүлэх Бүрэлдэхүүн хэсэг 3: Гарал үүсэл нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй малын гаралтай түүхий эд,

			бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх малчдын чадавхыг нэмэгдүүлж, бэхжүүлэх		
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	79,301,276 ам.доллар ¹		
		Эх үүсвэр	Төсөв (2022 он)	Гүйцэтгэл (2022 оны 11-р сарын 29-ний байдлаар)	Гүйцэтгэлийн хувь
		УАНС санхүүжилтээр	5,250,959	2,661,003	51%
		Хамтын санхүүжилтээр	20,785,156	9,217,477	44%
		НИЙТ	26,036,115	11,878,480	46%
6	Төслийн үйл ажиллагаа	<p>Төслийн 2022 оны төлөвлөсөн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 удаа шинэчлэн баталсан. 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг төслийн баримт бичиг, төсөл хэрэгжүүлэгч түншүүд, тухайлбал БОАЖЯ, ХХААХҮЯ, ОБЕГ болон орон нутгийн аймгуудын төлөөлөлтэй хийсэн өргөн хэлэлцүүлэгт үндэслэн 2022 оны төсөвт тусгагдсан төсөвтэй уялдуулан 2022 оны 05 дүгээр сарын 24 -ны өдрийн ТУХ-ын хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэн батлуулсан. УАНС-тай байгуулсан гэрээнд тусгагдсаны дагуу Хариуцагч талуудтай (ХХААХҮЯ, ОБЕГ, ЦУОШГ) гэрээ байгуулах, төсөлд хамрагдаж байгаа аймгуудыг Хариуцагч тал болгон нэмэх, гэрээ байгуулах, гэрээнд орон нутгийн хамтын санхүүжилтийг тусгах, орон нутагт худалдан авах ажиллагааны эрх шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн. Төслийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим үйл ажиллагаа “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хязгаарлагдсанаас “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тул Төслийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр тодотгол хийсэн бөгөөд 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгдүгээр бүрэлдэхүүний хүрээнд 29 арга хэмжээ, хоёрдугаар бүрэлдэхүүнд 41 арга хэмжээ, гуравдугаар бүрэлдэхүүнд 28 арга хэмжээ тус тус төлөвлөн хэрэгжүүлсэн.</p>			
7	<p>Бүрэлдэхүүн хэсэг 1:</p> <p>Үндэсний болон бүс нутгийн түвшинд газар, усны ашиглалтыг уур амьсгалын мэдээлэлд</p>	<p>Бүрэлдэхүүн 1 хэсгийн зорилтот үр дүнд хүрэхийн тулд дараах ажлууд хийгдэж байна.</p> <p>Бүрэлдэхүүн хэсэг 1.1: Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөгжлийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө болон дунд хугацааны хариу арга хэмжээний төлөвлөлт хийх мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх.</p>			

¹ Төслийн бичиг баримтад тусгагдсан нийт төсөв

<p>тулгуурлан төлөвлөж, хэрэглэдэг болох</p> <p>2022 оны зорилт:</p> <p>Тооцоолох төхөөрөмжийн худалдан авч ЦУОШГ-т суурилуулан, сургалт хийх. УАӨ-ийн нөлөөлөлд суурилсан урьдчилан сэргийлэх мэдээллийн системд шилжих, урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийн арга, аргачлал боловсруулах. Мал аж ахуйн үйлдвэрлэлд газар, усны тогтвортой менежментийг хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын шинэчлэлд шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ хийх. Төсөл хэрэгжүүлэх 4 аймгийн 31 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд мөн эдгээр аймгийн хэмжээнд оршдог 8 сав газрын менежментийн төлөвлөгөөнд уур амьсгалын эрсдэл, дасан зохицох байдлыг харгалзсан төлөвлөлт/шинэчлэл хийгдсэн байна</p> <p>Хүрэх үр дүн 1:</p> <p>Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөгжлийн төлөвлөлт хийх институцын болон эрх зүйн тогтолцоо бэхэжсэн байна.</p>	<p><u>1.1.1.Супер компьютер худалдан авч суурилуулан, техник ашиглалтын сургалт хийх, ЦУОШГ-ын барилга, эрчим хүч, агааржуулалтын системийн дүгнэлт гаргуулах, Супер компьютерын техникийн үзүүлэлтийн үнэлгээ хийхэд тендерийн үнэлгээний хороонд түслэх зөвлөх үйлчилгээ, ЦУОШГ-ын барилгын цахилгаан, агааржуулалтын системийн хүчин чадлыг нэмэгдүүлэх</u></p> <p>Ажлын биелэлт: ЦУОШГ-ын цаг агаарын урьдчилсан мэдээний техникийн хүчин чадал, тооцоолох төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх супер компьютерыг нийлүүлэх компанийг сонгох ажлын даалгаврыг боловсруулсан. Супер компьютерын техникийн тодорхойлолтыг бэлдэх нь техникийн нарийвчлал их шаардсан, нарийн төвөгтэй ажил, үйлчилгээ бөгөөд 1 сая ам.доллараас их төсөвтэй худалдан авалтын ажиллагаа тул НҮБХХ-ийн худалдан авах ажиллагааны дүрмийн дагуу зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд техникийн тодорхойлолт бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлэх техникийн зөвлөхийг нэмэлт байдлаар авч ажиллуулах шаардлага гарсан тул тус зөвлөх үйлчилгээ үзүүлэх экспертийг сонгох тендерийг 7 дугаар сарын 17-оос 9 дүгээр сарын 01-ний хугацаанд НҮБХХ-ийн худалдан авах ажиллагааны цахим системээр 4 удаа зарласан, шаардлага хангах зөвлөх саналаа ирүүлээгүй. Тиймээс НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн бүс нутгийн төлөөлөгчийн газраас 2022 оны 9-р сараас 11-р сарыг дуустал тендерийн баримт бичгийг хянан шалгаж, тендер зохион байгуулах эхлүүлэх зөвшөөрлийг 2022 оны 11-р сарын 29-ний өдөр олгосон. Олон улсын тендерийг 2022 оны 12 сарын 1-нд зарласан ба материал хүлээн авах эцсийн хугацаа нь 2023 оны 01 сарын 10-ны өдөр болно. Өндөр хүчин чадалтай супер компьютерыг суурилуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор ЦУОШГ-ын барилгын инженерийн хийц болон эрчим хүч, агааржуулалтын нөхцөлийг шалгаж, мэргэжлийн байгууллагаар техникийн дүгнэлт гаргуулах ажлыг төслөөс санхүүжүүлэн гүйцэтгэсэн. Техникийн үнэлгээгээр ЦУОШГ-ын барилгын цахилгааны шийдэлд засвар оруулж шинэчлэх, хөргөлтийн нөөц төхөөрөмж суурилуулах шаардлагатай дүгнэлт гарсан. Уг ажлын нийт төсөвт өртөг нь 209,998,362 төгрөг болохыг үнэлгээгээр тооцоолсон. Барилгын цахилгааны шийдэлд засвар оруулж шинэчлэх, хөргөлтийн нөөц төхөөрөмж суурилуулах ажлын төсөв нь төслийн төсөвт багтаагүй ч төслийн Удирдах Хороогоороо энэ асуудлыг хэлэлцүүлэн зардлыг супер компьютерыг худалдан авах нийт дүнгээс гаргуулахаар шийдвэрлүүлсэн. Супер компьютерыг хүлээн авч суурилуулахад шаардлагатай барилгын засвар, шинэчлэлийн ажлыг гүйцэтгэгчийг сонгох ажлын даалгаврыг боловсруулан, БОАЖЯ-ны ТНБД-аар батлуулсан бөгөөд тендерийг ЦУОШГ зохион байгуулж байна.</p> <p><u>1.1.2 Цаг агаарын судалгаа, урьдчилан таамаглах загварчлал, дэлхийн системийн загварчлал, агаар мандлын</u></p>
--	---

судалгааны үндэсний төвийн командын хэлийн ашиглах чиглэлийн сургалт хийх

Ажлын биелэлт: Цаг агаарын дунд, урт хугацааны мэдээ боловсруулахад шаардлагатай загварчлал, мэдээ боловсруулалт хийх, дүн шинжилгээ анализ хийхэд ЦУОШГ-ын ажилтнуудын чадавхжуулах ажлын хүрээнд олон улсын зөвлөх Япон улсын Хирошимагийн их сургуулийн профессор Хан Су Ли-г урьж авчран 2022 оны 9 дүгээр сарын 12-оос 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд танхимын болон ажлын байран дээрх сургалтыг хийсэн. Сургалтад УЦУОСМХ-ийн 5 хэлтсийн дунд болон ахисан түвшний 22 инженер, судлаачид хамрагдлаа. Сургалт тоон прогноз, загварчлал, бүс нутгийн цаг агаарын WRF-ARW загвар болон NCAR командын хэл, дэлхийн систем-уур амьсгалын загвар, өгөгдлийн ассимиляц, WRFhydro урсцын загвар зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан.

1.1.3. Уур амьсгалын эрсдэлийн мэдээлэлд суурилсан газар, ус, мал аж ахуйн төлөвлөлтийн удирдамж, зааварчилгаа бүхий гарын авлага боловсруулах

Ажлын биелэлт: Уур амьсгалд тэсвэртэй хөгжлийг улс, аймгийн хэмжээнд хангах зорилгын хүрээнд газар, ус, мал аж ахуйн менежментийн уур амьсгалын эрсдэлд суурилсан төлөвлөлтийн заавар, заавар, арга зүй, гарын авлага боловсруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Газар, ус, мал аж ахуйн менежментийн уур амьсгалын эрсдэлийн мэдээлэлд суурилсан төлөвлөлтийн заавар, зааварчилгааны арга зүй, гарын авлагыг боловсруулах олон улсын зөвлөх, дотоодын зөвлөх багийн ажлын даалгаврыг 2022 оны 7 дугаар сард батлуулж, 2022 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр дотоодын зөвлөх багтай, 2022 оны 12 сарын 06-ны өдөр дотоодын (тэргүүлэх) зөвлөхтэй гэрээг тус тус байгуулсан. Үндэсний зөвлөхүүд мэдээлэл цуглуулах, боловсруулах, урьдчилан таамаглах чадвар, салбарын төлөвлөлтийн одоогийн байдалд анализ хийж байна.

1.1.4. Үндэсний болон аймгийн түвшний дүнд хугацааны хөгжлийн төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлж, уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, урьдчилсан таамаглалд үндэслэсэн санхүүжилтийн арга аргачлалыг боловсруулах

Ажлын биелэлт: Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийг үндэсний хэмжээнд дунд хугацааны төлөвлөлтийн боловсруулалтад тусгах зорилгоор уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилан таамаглах (IBF) болон таамаглалд суурилсан санхүүжилтийн (FBF) удирдамж, арга зүйг боловсруулах олон улсын болон дотоодын зөвлөхийн ажлын даалгавар 2022 оны 07 дугаар сард батлагдсан. Олон улсын зөвлөх Сажокадул Исламтай 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр гэрээ байгуулсан. Дотоодын зөвлөх багаар шалгарсан Цаг уур, ус, байгаль орчны мэдээлэл, судалгааны хүрээлэнтэй 2022 оны 10-р сарын 07-нд гэрээ байгуулсан. Зөвлөх баг нь одоо байгаа арга зүй, цаг уурын хүлээгдэж буй нөхцөл байдал,

холбогдох цаг уурын нөлөөллийн тодорхой хугацаанд мөрдөгдөж буй удирдамжийг боловсруулж байна.

1.1.5.а Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлж буй малчдын байгууллага, эко-малчдыг дэмжин чадваржуулах контент боловсруулах, түгээх.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой шалгуурыг хангасан уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх гол хүчин зүйл юм. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэгч малчдын байгууллага, хариуцлагатай малчдыг дэмжих, чадавхжуулах нь төслийн зорилго, зорилтод бүрэн нийцэж байгаа бөгөөд цаашид гарч болзошгүй байгалийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх үндэс суурь тул тус чиглэлээр малчдад чиглэсэн малчны байгууллага, эко малчдыг дэмжих, чадавхжуулах контентыг хийх ажлын даалгаврыг боловсруулж 2022 оны 7 дугаар сард батлуулсан. Цахим тендер зохион байгуулж шалгарсан “Эконто” ХХК-тай 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээт байгууллага 4 бүлэг сэдэв бүхий 1 комик ном, тус бүр нь 1 минутын хугацаатай 4 анимэйшн гаргаад байна. 2023 онд зорилтот 4 аймгийн малчдад зориулан хэвлэж, түгээнэ.

1.1.5.б Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох сэдвээр эрдэм шинжилгээний хурал, оюутны олимпиад зохион байгуулах

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл багатай даван туулахад залуучуудын оролцоог дэмжих зорилгоор 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Улсын Экологийн XVIII олимпиадыг “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” сэдвээр БОАЖЯ, МУИС-тай хамтран зохион байгуулсан. Мөн байгалийн нөөцийн зохистой ашиглалтын талаар залуу судлаачдад зориулсан “Зөвхөн нэг дэлхий” оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан. Эдгээр ажлууд нь салбарын залуу судлаачдыг эрдэм шинжилгээний ажилд сургах, бүтээлч сэтгэлгээг нь хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр онол, практикийн мэдлэг олгох ач холбогдолтой болсон.

1.1.6. Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний аргачлал боловсруулах

Ажлын биелэлт: Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний аргачлал боловсруулах 4 хувь зөвлөхийг 2022 оны 7 сарын 21-нд шалгаруулж гэрээ байгуулан, судалгааны ажлыг эхлүүлсэн. Зөвлөхүүд нь Засгийн газрын 2019 оны 1 сарын 19-ний өдрийн тогтоолоор батлагдсан “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний журам”-ын дагуу байгалийн гаралтай гамшигт үзэгдлийнхохирол, хэрэгцээг тооцох аргачлалыг боловсруулж, ОБЕГ, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, ЦУОШГ, Сангийн яам, Эрчим хүчний яам, ХХААХҮЯ зэрэг

байгууллагуудын төлөөллүүдэд танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн 2022 оны 11 сарын 18-ны өдөр Ховд, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар, ОБЕГ, Цагдаа, МХЕГ, Статистик, БОАЖГ, ЦУОШГ зэрэг байгууллагуудын төлөөллүүдэд зориулан байгалийн гаралтай гамшигт үзэгдлийн хохирол, хэрэгцээг бодит жишээн дээр тооцох сургалтыг зохион байгуулсан. Хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг, сургалтын үеэр гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн, аргачлалын төслийг сайжруулсан. Сайжруулсан эцсийн хувилбарыг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр ОБЕГ-т хүргүүлж тус газрын газар, хэлтсийн албан хаагчдын дунд хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, холбогдох албаны төлөөлөгчдөөс санал авсан. Мэргэжлийн байгууллагуудаас гаргасан санал, зөвлөмжийг тусган боловсруулсан гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний аргачлалыг ОБЕГ -т хүлээлгэн өгсөн.

1.1.7. Байгаль орчны зорилтот хөтөлбөр боловсруулах үүр амьсгалын өөрчлөлтийн дэд ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх

Ажлын биелэлт: БОАЖЯ-ны захиалгаар байгаль орчны зорилтот хөтөлбөр боловсруулах уур амьсгалын өөрчлөлтийн дэд ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх богино хугацааны зөвлөхийг авч ажиллуулсан. Зөвлөх нь байгаль орчны болон бусад 6 зорилтот хөтөлбөрүүдэд төслийн үндсэн зорилго, үйл ажиллагааг тусгах чиглэлээр анхаарч БОАЖЯ-ны зорилтот хөтөлбөр боловсруулах дэд ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж ажилласан.

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан

1.1.2 Төсөл хэрэгжих 4 аймгийн орон нутгийн холбогдох төрийн байгууллагуудын оролцоотойгоор эдгээр аймгуудад үүр амьсгалын өөрчлөлтийн нөхцөл байдлыг тодорхойлох үнэлгээ хийх.

Ажлын биелэлт: Зорилтот аймгуудын УАӨ, хандлагыг цаг уурын станцын 1940-2020 оны хур тунадас, агаарын температурын ажиглалтын мэдээг орон зайд нарийвчлах арга, загвар ашиглан 9км x 9км торын цэгт хөрвүүлж тодорхойлсон зураглал, 4 аймгийн агаарын температур, хур тунадасны 2100 он хүртэлх ирээдүйн төлөвийн зураглал гаргасан. Энэ ажлын хүрээнд уур амьсгалын эрсдэлийг үнэлэх болон нэгдсэн үнэлгээний загварчлал (IAM) ашиглан нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэл, тэсвэртэй байдлыг үнэлэх аргачлалыг судалж УАӨ, байгалийн нөөц, экосистемийн үйлчилгээний орон зайн ялгаатай байдал, он цагийн өөрчлөлтийн мэдээлэл ашиглан үнэлэх арга, мэдээлэл боловсруулах технологи гаргах ба УАӨ-ийн нөлөөллийн үнэлгээг хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах систем динамикийн судалгааны ажил хийгдэж байна. Судалгааны үр дүнг 2022 оны 09 дүгээр сард 4 аймгийн төлөвлөлтөд оролцдог байгууллагуудын төлөөлөлд танилцуулж санал авсан. Мөн өнгөрсөн 82 жилийн ган, зудын байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын чиг хандлагыг 4

аймгийн хэмжээнд тооцсон. Төслийн баг уур амьсгалд тэсвэртэй эдийн засгийн загварчлалыг боловсруулах чиглэлээр Эдийн засгийн хөгжлийн яамтай нягт хамтран ажиллаж байгаа бөгөөд гаргасан загварыг Эдийн засгийн хөгжлийн яаманд хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна. Зорилтот аймгуудын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн дүн шинжилгээ, эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг 2023 оны эхний улиралд багтаан хийж дуусгана. Газар ашиглалтын менежментийн төлөвлөгөө, УННМ төлөвлөгөөний үндэс болох холбогдох газрын зургийг гаргана. Одоо байгаа болон болзошгүй байгалийн гамшиг, эрсдэл, эмзэг байдалд үндэслэн 2 аймгийн 2 сумын эдийн засгийг хөгжүүлэх загвар гаргана.

1.1-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо: 9

Гүйцэтгэлийн хувь: 70 %

Үйл ажиллагаа 1.2: Аймаг, сумын хөгжлийн төлөвлөлтийг бэлчээрийн даац, уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэлд үндэслэн гаргах, гол мөрний сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг шинэчлэх

1.2.1. Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгийн 31 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлийг тусган шинэчлэх/шинээр боловсруулах

Ажлын биелэлт: Монгол Улсын бараа, ажил, зөвлөх үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгийн 31 сумын НДХТ-г боловсруулах ажлын сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Сонгон шалгаруулалтын жишиг журмаар хоёр сарын дараа үндэсний 4 компани шалгарч, гэрээ байгуулсан. Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ, дасан зохицох онцлог шинж чанаруудыг харгалзсан сумдын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгийн 31 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах ажлыг "Газар дэлхий" ХХК, "Вектор меп" ХХК, "Ланд овнер" ХХК, "Тэгшхэм" ХХК нь шинэчилсэн арга зүй, аргачлалын дагуу гүйцэтгэж байна. 2023 оны 2-р улиралд багтааж сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлийг тусган боловсруулж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн ГХГЗЗГ-аар баталгаажуулна.

1.2.2. Газар, усны төлөв байдал, чанарын мониторинг, үнэлгээг зайнаас тандах технологийг ашиглан сайжруулах

Ажлын биелэлт: Газар, усны нөөцийг зайнаас тандан судлах технологи, түүний чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг боловсронгуй болгох ажлын даалгаврыг боловсруулж сонгон шалгаруулалтыг БОАЖЯ-наас зохион байгуулсан. 2022 оны 9-р сарын 21-ний өдөр Софт мастер ХХК-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. Эхлэлийн тайланг хүлээн авсан. Ажлыг үр дүнд газрын төлөв байдал, чанарын мониторингийн цахим системийг egazag.gov.mn дээр харагдах бүтэц загварыг хөгжүүлэлтийг веб систем болон цахим системд давхар хөгжүүлэлт хийж, иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон бүх шатны төрийн байгууллага газартай холбоотой бүх мэдээллийг нэг дороос харах боломж бүрдэнэ. Тус ажлыг 2023 оны 1-р улиралд багтааж дуусна.

1.2.4. Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгийн газар нутагт буй 8 сав газрын менежментийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан шинэчлэх/шинэчлэн боловсруулах

Ажлын биелэлт: 8 сав газрын менежментийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан шинэчлэх/шинэчлэн боловсруулах ажлын хийх дотоодын зөвлөх багийг сонгон шалгаруулалт 2 багцаар зохион байгуулсан. 2022 оны 9-р сарын 01-ний өдөр баруун бүс нутагт байрлах 3 сав газрын менежментийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан боловсруулах ажлыг гүйцэтгэгчээр Престиж Инженеринг ХХК шалгарч гэрээ байгуулсан. Эхлэл, явцын тайлангуудыг ирүүлж, хээрийн ажлыг дуусгасан. Хоёр дахь багц буюу зүүн бүсийн 5 сав газрын менежментийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан шинэчлэн боловсруулах ажлын сонгон шалгаруулалт амжилтгүй болж тендерийг 2022 оны 8-р сарын сүүлчээр дахин зарлаж, 2-р багцын гэрээг 2022 оны 11-р сарын 04-ний өдөр байгуулсан. Эхлэлийн тайланг 2022 оны 12-р сарын 02-нд ирүүлсэн. Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийг 8 голын сав газрын төлөвлөгөөнд тусгах ажил үргэлжилж байна. Баруун бүсийн 3 сав газрын менежментийг төлөвлөгөө 2023 оны 1 -р улиралд багтаан, Зүүн бүсийн 5 сав газрын менежментийн төлөвлөгөө 2023 оны 03-р улиралд багтаан дуусгаж хүлээлгэж өгнө. Энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд БОАЖ-ын сайдын "Аргачилсан заавар батлах тухай" 2020 оны 01 сарын 24-ний өдрийн тушаалаар батлагдсан "Сав газрын УННМТ-г боловсруулах аргачилсан заавар"-т уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, эрсдэл, эмзэг байдлыг уялдуулан тооцож дасан зохицох төлөвлөлт хийх нэмэлт өөрчлөлт оруулах юм.

1.2.5 Буйр нуур, цутгал голуудын экосистем, нуурын ёроолын болон биологийн төрөл зүйлийн судалгааг хийх зохистой ашиглах, хамгаалах дасан зохицох төлөвлөгөөг Буйр нуур Халх голын сав газрын төлөвлөгөөнд тусган

хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Ажлын биелэлт: Дорнод аймгийн нутаг дэвсгэрт орших Буйр нуурын экосистемийн суурь судалгаа, нуурын ёроолын болон биологийн олон янз байдлын судалгааг нарийвчлан хийж байна. Судалгааны үр дүнд Буйр нуур, Халх голын сав газрын төлөвлөгөөнд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалд дасан зохицох хамгааллын арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх боломжтой болох юм. Тус судалгааг "Найчрал састайнэблэ" ХХК хийж байгаа ба хээрийн судалгаандаа 2022 оны 09 дугаар сарын 20-ноос 10 дугаар сарын 25-ны хооронд ажиллаж, нуурын биологийн олон янз байдал /хясаа, загасны төрөл зүйлийн судалгаа/, эргийн экосистемийн судалгаанд шаардлагатай дээж авч, боловсруулалтыг хийж байна. Хээрийн судалгааны үр дүнд Халх голд урьд өмнө бүртгэгдэж байгаагүй загасны шинэ төрөл зүйлийг илрүүлээд байна. Хилийн цэргийн ерөнхий газар, ГХГЗЗГ-тай хамтран нуурын ёроолын хэмжилтийн ажлыг хийхэд шаардлагатай бэлтгэл ажлыг хангаад байна. Харин нуурын давлагаа 09-10 сард 1-2 баллын хүчтэй байсан тул Буйр нуурт хэмжилт хийх хориог Хилийн цэргийн газраас тавьсан. Хэмжилтийн ажлыг 2023 оны 06-08 сард үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 1.2.1.

Улс, аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад УАӨ-ийн мэдээллийг түсгэн сайжруулах

Ажлын биелэлт: Улс болон аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргазүй, аргачлалд УАӨ-ийн мэдээллийг уялдуулсан байдлыг үнэлж, сайжруулах ажил төлөвлөгдсөн. Төслийн 2 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон эдгээр аймгийн 9 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө (НДХТ)-нд үнэлгээ хийж, сайжруулах зөвлөмж боловсруулах, уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдал, дасан зохицох мэдээлэл, онцлогуудын тусгасан нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 6 суманд шинээр хийх ажил төлөвлөгдсөн. Энэ ажлыг гүйцэтгэх зөвлөх багаар "Лапланд эко" ХХК шалгарч, 2022 оны 05 сарын 02-ны өдөр гэрээ байгуулан, ажлаа эхлүүлээд байна. Үйл ажиллагааны 1.1 хүрээнд хийгдэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээний үр дүнд үндэслэн улс болон аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргазүйг шинэчлэн сайжруулахаар Зөвлөх баг ажлаа эхлүүлсэн. Үйл ажиллагааны 1.1-ийн хүрээнд хийгдсэн судалгааны ажлын эхний шатны үр дүнг 2022 оны 06 сарын 03-ны өдөр Лапланд эко ХХК-нд танилцуулж, судалгааны үр дүнд суурилан 2 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 9 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийж, тодотгол хийх, 6 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах ажил хийж байна. 2022 оны 7-8 сард хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэж, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах арга зүйд уур

амьсгалын өөрчлөлтийн мэдээнд үндэслэн төлөвлөлт хийдэг болгоход чиглэсэн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулаад байна. Арга зүйн төслийг ГХГЗЗГ, Усны агентлаг, ЦУОШГ гэх зэрэг холбогдох талуудын дунд 022 оны 10 дугаар сарын 28-нд хэлэлцүүлэн, хэлэлцүүлгээс гарсан саналд үндэслэн арга зүйг сайжруулж, ГХГЗЗГ-т хүргүүлсэн. Ховд, Завхан аймгийн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд уур амьсгалын асуудлыг тусгах тодотгол хийх зөвлөмж боловсруулах, 2 аймгийн 9 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд зөвлөмж боловсруулсан.

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд түсгагдсан 1.2.2. Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгийн газар нутагт буй 6 сав газрын менежментийн төлөвлөгөөг үүр амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан боловсруулах

Ажлын биелэлт: УННМТ боловсруулах аргазүй, аргачлалд уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийг уялдуулсан байдлыг үнэлэх, төсөл хэрэгжих аймгуудын нутаг дэвсгэрт байрлах 3 голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлын судалгааг уялдуулан шинээр боловсруулах, 3 сав газрын төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийх ажил төлөвлөгдсөн. Мөн 4 аймгийн нутаг дэвгэрт хамаарах 8 голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлын судалгааг нэмэлтээр хийж, тодотгол хийнэ. Мөн энэ ажлын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах одоогийн аргачлалыг сайжруулж, нэмэлт өөрчлөлт оруулах ажил хийгдэхээр төлөвлөсөн. Тус ажлын сав газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах үндэсний зөвлөх багаар Эколандшафт ХХК шалгарч, 2022 оны 04 сарын 29-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээт компани ажлын даалгаварт заасан ажлыг батлагдсан төсөв, хугацаанд нь биелүүлэх боломжгүй болсон тул БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 9-р сарын 01-ний өдрийн албан бичгээр гэрээг 2022 оны 8-р сарын 29-ний өдөр цуцалсан. Уг ажлыг 2023 оны үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган ажлын даалгаврыг дахин шинэчлэн боловсруулж байна.

Гарах үр дүн: Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгийн 6 сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан шинэчлэн боловсруулсан байна. Тус судалгааны үр дүнгээс Бүрэлдэхүүн хэсэг 2-т хийгдэх ЭТДЗ-н ажлуудыг хэрэгжүүлэх (Жишээлбэл: татмын ойн нөхөн сэргээлт, худаг гаргах/сэргээн засах, усжуулалтын системийг сайжруулах, хөв цөөрөм байгуулах гэх мэт) цэгүүд тодорхой болно. Тухайн сав газрын аймаг сумд судалгаанд суурилж дасан зохицох арга хэмжээг төлөвлөдөг болно.

1.2-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо: 6

Гүйцэтгэлийн хувь: 50%

Үйл ажиллагаа 1.3: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр үүсэх эрсдэлийг даван туулах чадвартай мал аж ахуйн үйлдвэрлэлд газар, усны тогтвортой менежментийг хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын шинэчлэлд шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ хийх

1.3.1. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй МАА-н салбарыг хөгжүүлэх хууль эрх зүйн шинэчлэл хийх

Ажлын биелэлт: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй МАА-н салбарыг хөгжүүлэх хууль эрх зүйн шинэчлэл хийх зөвлөх үйлчилгээ ажлыг гүйцэтгэгчээр “Бүсчилсэн хөгжил судалгааны төв” ТББ шалгарч гэрээг 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан. Энэхүү судалгаагаар мал аж ахуйн салбартай холбоотой хэрэгжиж байгаа хууль эрх зүйн баримт бичиг Монгол улсын хууль, УИХ-ын тогтоол, бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, экосистемийн үйлчилгээнд суурилсан Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах, шинэчлэл хийх хэрэгцээ, шаардлага, үндэслэлүүдийг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх бодлогын шийдэл, хувилбаруудыг гаргах болно. Зөвлөх багийнхан хууль эрх зүй, бодлогын өөрчлөлтийн хувилбаруудыг 2023 оны 2-р хагаст гол оролцогч талуудад танилцуулж, хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

Гарах үр дүн: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, экосистемийн үнэлгээнд суурилсан шинэчилсэн МАА-н салбарын шинэчилсэн бодлогын хувилбарууд бүхий МАА-н салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан байна.

1.3.2. Экосистемийн үйлчилгээнд суурилсан хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөдөө аж ахуйн салбарт нэмэгдүүлэх хувилбарыг гаргах зөвлөх үйлчилгээ, хэлэлцүүлэх үүлзэлт зохион байгуулах

Ажлын биелэлт: Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд байгалийн нөөц (бэлчээр, ус) ашиглах, мал аж ахуйн эрхлэхэд улсын болон орон нутгийн төсвөөс зарцуулж буй хөрөнгө оруулалтад дүн шинжилгээ хийж, байгалийн нөөц ашиглалт, мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэхэд үйлдвэрлэл эрхлэгчдэд зохистой хөрөнгө оруулалтын болон дасан зохицох арга ажиллагаанд дэмжлэг үзүүлэх оновчтой хувилбарыг боловсруулна. Экосистемийн үйлчилгээний дүн шинжилгээнд үндэслэн хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хувилбаруудыг санал болгох олон улсын зөвлөх болон дотоодын зөвлөх багийг сонгон шалгаруулж авах ажлыг 2022 оны 7-р сарын 01-ний өдөр НҮБХХ-д олгосон. Олон улсын зөвлөхөөр ноён Леандро Фернандест шалгарч гэрээ хийсэн. Дотоодын зөвлөх багаар шалгарсан “Байгаль

		<p>хамгаалал, тогтвортой хөгжил” ТББ-тай гэрээ байгуулж, 2022 оны 10 дугаар сараас гэрээт ажил эхэлсэн. 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, сонгогдсон Дорнод, Ховд аймагт экосистемийн үйлчилгээний төлбөрийг хэрэгжүүлэх оновчтой аргачлалыг хэлэлцэн, зөвлөгөөний үр дүнд экосистемийн үйлчилгээний төлбөрийг тооцох аргачлалыг гаргав. Аргачлалын дагуу судалгааны ажил эхэлсэн.</p> <p><u>2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 1.3.1 Байгалийн нөөц (ус) ашиглалт болон мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж, үүр амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицсон, даван түүлах чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд байгалийн нөөцийг зохистой, тогтвортой ашиглах бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах санал боловсруулах</u></p> <p>Ажлын биелэлт: 2022 оны 6 дугаар сарын эхээр дотоодын зөвлөхөөр А.Саулегул шалгарсан боловч 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр өөрийн хүсэлтээр гэрээг цуцалсан. Ажлын даалгаврыг дахин боловсруулж 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр зөвлөх сонгон шалгаруулах цахим тендерийг эхлүүлсэн. 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр доктор Г.Долгорсүрэнтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Эхлэлийн тайланг 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр ирүүлсэн. Зөвлөх бэлчээр, малын усан хангамжийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах зорилгоор төсөл хэрэгжих аймгуудад ажиллаж байна. Төслийн бэлчээр ус хангамжийн бодлогын зөвлөх доктор Г.Долгорсүрэн нь 4 аймгийн бэлчээрийн ус хангамжийн цэгүүдийн одоогийн зураглалыг сум тус бүрээр гаргаж, цаашид уст цэгийг шинээр гаргах, сайжруулах, засварлах нэгдсэн чиглэлийг тодорхойлж, МАА-н салбарын бодлогын баримт бичигт уялдуулан тусгах болно.</p> <p>1.3-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо: 3</p> <p>Гүйцэтгэлийн хувь:50%</p>
	<p>Бүрэлдэхүүн хэсэг: 2</p> <p>Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ус, хөрсний менежментийн арга ажиллагааг өргөн хүрээнд нэвтрүүлэн малчдын оролцоог байгалийн нөөцийн хамтын ажиллагаанд нэмэгдүүлэх</p>	<p>Бүрэлдэхүүн 2 хэсгийн зорилтот үр дүнд хүрэхийн тулд дараах ажлууд хийгдэж байна.</p> <p>Үйл ажиллагаа 2.1: Байгалийн нөөцийг зохистой ашиглах хамтын ажиллагааны хэлбэрийг боловсронгуй болгох, бэлчээр, усны нөөцийн хамгааллыг дэмжих</p> <p><u>2.1.1. Тэргүүний малчдын түршлагыг түгээн дэлгэрүүлэх, ус, бэлчээрийн нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалт ба нөхөн сэргээлтийн чиглэлээр малчдын хандлагыг өөрчлөх бүсчилсэн сургалт, зөвлөгөөнийг төслийн 4 аймагт зохион байгуулах</u></p>

<p>2022 оны зорилт:</p> <p>Уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулан байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр малчид, малчдын байгууллагын чадавх бэхжүүлэх болон дасан зохицох арга хэмжээ болон татмын ойн нөхөн сэргээлт, булаг шандын эхийг хамгаалах, тэжээлийн агуулах, өвсний саравч барих зэрэг ажлуудыг хэрэгжүүлж эхлэх</p> <p>Хүрэх үр дүн 2:</p> <p>Уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулан байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр малчид, малчдын байгууллагын чадавх бэхжүүлэх болон дасан зохицох арга хэмжээ болон татмын ойн нөхөн сэргээлт, булаг шандын эхийг хамгаалах, тэжээлийн агуулах, өвсний саравч барих зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Ажлын биелэлт: “Малчдын туршлагыг түгээн дэлгэрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэхэд малчдын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт малчдын зөвлөгөөнийг төслийн 4 аймагт зохион байгуулсан. Зөвлөгөөнд сум бүрээс малчид, малчдын байгууллагыг төлөөлж 900 малчид (үүнээс 300 гаруй нь эмэгтэй), сум орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийн төлөөлөл 100 гаруй хүн оролцсон. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг танилцуулах, орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудтай төслийн хэрэгжилтийн уялдааг хангах, малчдын бүлэг, хоршоотой хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, малчдад малын тооноос чанарт шилжих ач холбогдол, бодлогын загвар, түүнийг хэрэгжүүлэх арга зам, сайн туршлага болон “Хариуцлагатай нүүдэлчин” стандарт, түүний шалгуур үзүүлэлт, мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг нэмэгдүүлэхэд мөшгөх тогтолцооны ач холбогдол зэргийн талаар танилцуулсан. “Малчдын зөвлөгөөн”-нд тавигдсан илтгэлүүд, хэлэлцүүлгийн үр дүн болон оролцогчдын саналыг үндэслэн малчид хоорондоо хамтран ажиллах, малын эрүүл мэндийг хамгаалах, малын ашиг шим, үүлдэр, угсааг сайжруулах, бэлчээрийг зохистой ашиглах, мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх уриалга болон 10 чиглэл бүхий зөвлөмж гаргав. Уриалга: “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээр ашиглалтын гэрээтэй, байгалийн нөөцийн даацад тохирсон эрүүл, ашиг шим өндөр мал сүрэгтэй, МАА-н бүтээгдэхүүнээ төвлөрсөн цэгээр боломжийн үнэтэйгээр дотоод, гадаадын зах зээлд борлуулдаг, хоршсон хамтын ажиллагаатай, хариуцлагатай, эко системийн төлбөр авдаг малчин бүхий тогтвортой мал аж ахуйн үйлдвэрлэл хөгжүүлэхэд төсөлтэй хамтран ажиллана” гэсэн бөгөөд уриалгын хүрээнд хамтран ажиллаж байна.</p> <p><u>2.1.3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох усны эхийг хамгаалах, ойжуулалтын арга хэмжээг “Тэрбум Мод” үндэсний хөдөлгөөнтэй уялдуулан ойжуулалтын ажлын зохион байгуулалт, чанарыг сайжруулах сургагч багш бэлдэх бүс нутгийн сургалт зохион байгуулах</u></p> <p>Ажлын биелэлт: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний хүрээнд усны эхийг хамгаалах, ойжуулалтын арга хэмжээг “Тэрбум Мод” үндэсний хөдөлгөөнтэй уялдуулан ойжуулалтын ажлын зохион байгуулалт, чанарыг сайжруулах сургагч багш бэлдэх бүс нутгийн сургалтыг сум бүрд 2 сургагч багш бэлдэхээр төлөвлөсөн. Уг ажлыг БОАЖЯ-ны Ойн Бодлого Зохицуулалтын газар, МУИС-ийн Ойн хүрээлэнтэй хамтран төслийн гурван зорилтот аймагт (Ховд, Сүхбаатар болон Дорнод аймгууд) хээрийн сургалт хэрэгжүүлсэн. Мөн 06 дугаар сарын 13-23-ны өдрүүдэд Дорнод, Сүхбаатар аймгуудад, 09 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд Ховд аймагт тус тус зохион байгуулагдаж, 132 сургагч багш бэлтгэгдсэн. Мөн цахим хэлбэрээр 5 дугаар сарын 13-21-ний өдрүүдэд нийт 1000 гаруй оролцогч оролцсон сургалтыг зохион байгуулсан.</p>
---	--

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 2.1.1. Төслийн 4 аймагт ой, бэлчээр, газар, усны нөөцийн менежментийн (ашиглалт, хамгаалал, нөхөн сэргээлт) чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөл, хоршоонд үнэлгээ хийх, байгалийн нөөц ашиглалтын гэрээг боловсронгуй болгох

Ажлын биелэлт: Дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөл, хоршооны хамтын ажиллагааны арга барил, бүртгэл, эрх зүйн орчин, цаашдын хэрэгцээ болон тулгамдаж буй асуудлын талаар үнэлгээ хийх, нөөц ашиглах гэрээг боловсронгуй болгох ажлын сонгон шалгаруулалтад Дорнод, Сүхбаатар аймгийн хэмжээнд Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо ТББ, Ховд, Завхан аймгийн хэмжээнд Бодлого судлалын төв ТББ шалгаран гэрээ байгуулсан. Энэ ажлын онцлог нь 4 аймгийн бүх сумдыг хамарч байгаагаараа, бүх малчдын оролцоог ханган нэн ялангуяа уур амьсгалын эрсдэлтэй, эмзэг газруудад цаашид хэсэг, бүлэг, нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад оруулж хамтран бэлчээр, хадлан, ус, ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлуудыг хийх нөхцөлийг бүрдүүлж, тогтвортой байдлыг хангахад суурь болох юм. Төсөл хэрэгжиж буй 4 аймагт ой, бэлчээр, газар, усны нөөцийн менежментийн (ашиглалт, хамгаалал, нөхөн сэргээлт) чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөл, хоршоонд үнэлгээ хийх, байгалийн нөөц ашиглалтын гэрээг боловсронгуй болгохоор дээрх чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой бүлэг, нөхөрлөл, хоршооны хамтын ажиллагааны арга барил, бүртгэл, эрх зүйн орчин, цаашдын хэрэгцээ болон тулгамдаж буй асуудлын талаар үнэлгээ хийх, нөөц ашиглах гэрээг боловсронгуй болгох ажил хийгдсэн. Зөвлөх багууд ажлын даалгаварт тусгагдсаны дагуу хээрийн судалгааны ажил, дүн шинжилгээ боловсруулалтыг эцэслэж, 11 дугаар сарын төслийн Техникийн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн. Хурлаар ТАХ-ын гишүүдээс гарсан санал, шүүмж, зөвлөмжийг тайланд тусгууллаа. Техникийн ажлын хэсгийн гишүүд эцсийн тайланг хүлээж авч баталгаажуулсан. Гэрээт ажлыг бүрэн хүлээж авсан. Дараах үр дүнд хүрсэн.

1. Завхан, Ховд, Дорнод, Сүхбаатар аймгийн 68 сумдыг хамран малчдын байгууллагын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө, нэгдсэн бүртгэл гарсан.
2. Зорилтот аймгуудад уур амьсгалын өөрчлөлтөд тогтвортой бэлчээр, усны нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд одоогийн байгаа малчдын оролцоотой малчдын байгууллагыг эрчимжүүлэх болон уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, эрсдэлтэй газарт шинээр бүлэг, нөхөрлөл, хоршоог байгуулах талаар зөвлөмж гарч нөөц ашиглах гэрээг сайжруулах, шинээр боловсруулах ажил хийгдсэн.

3. Гарсан зөвлөмжийг малчдын үйлдвэрлэгч байгууллага, түншлэлийг сайжруулах ажлын суурь болгон ашиглах боломжтой болсон.

2.1-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо: 3

Гүйцэтгэлийн хувь 100%

Үйл ажиллагаа 2.2: Татмын ойн нөхөн сэргээлт хийх замаар усны нөөц, экосистемийн үйлчилгээг тэтгэх

2.2.2. Ой, ус, бэлчээрийн менежментийн чиглэлийн 3 үндэсний зөвлөх, усны нөөцийн менежмент, ойжуулалтын чиглэлийн 4 (аймаг бүрд 1) орон нутгийн богино хугацааны зөвлөх ажиллуулах

Ажлын биелэлт: Төслийн нэгжид ой, ус, бэлчээрийн чиглэлийн тус бүр 1, аймаг тус бүрд усны нөөцийн менежментийн, эсвэл ойжуулалтын чиглэлийн тус бүр 1, нийт 7 богино хугацааны зөвлөхийг 5 сарын хугацаатай авч ажиллуулан, төслийн үйл ажиллагаанд оролцуулах ажлын хүрээнд төслийн нэгж, оролцогч талуудаас санал авч, тухайн орон нутагт шаардлагатай байгаа мэргэжилтэн зөвлөхүүдийн судалгааг хийсэн. Хувь зөвлөх бүрээр ажлын даалгавар боловсруулагдаж гарсан. Үндэсний зөвлөхүүд дасан зохицох арга хэмжээ хэрэгжих байршлын сонголт, хэрэгжүүлэх арга замууд дээр мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллаж байгаа бол орон нутгийн зөвлөхүүд тухайн аймагт хийгдэх татмын ойжуулалт, бэлчээрийн менежмент, булгийн эхийг хашиж хамгаалах, хөв, цөөрөм, газрын доорх усыг хуримтлуулах систем барьж байгуулах судалгаа, тооцоо хийх зэрэг шаардлагатай ажлуудад оролцон ажиллаж байна.

Гарах үр дүн: 2022 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан, 2023 оны төлөвлөгөөнд орох ажлуудад мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, хөндлөнгийн хяналтын үүрэг гүйцэтгэнэ.

2.2.3. Төслийн 4 аймагт татмын ойжуулалтыг ажлыг хэрэгжүүлж эхлэх

Ажлын биелэлт: Зорилтот 4 аймагт 2022 онд татмын ойжуулалт хийх боломжит байршлуудын судалгааг аймгийн БОАЖГ, холбогдох СГЗ-аас авч нэгтгэсэн. БОАЖ-ын Сайд, Сангийн Сайдын хамтарсан 2021 оны А/172, 116 тоот зардлын нормативын дагуу татмын ойжуулалтыг “Навчит модны бортоготой тарьцаар ойжуулах”-д 1 га талбайн төсөвт өртөг 3000 ам доллар болсон. УАНС-аас батлагдсан төсөв 1 га талбайд 1000 ам доллар байгаа тул төслийн баримт бичигт тусгагдсан хамтын санхүүжилт хийх хариуцагч талуудтай гэрээ байгуулах ажил хийгдсэн. Зорилтот 4 аймгийн хэмжээнд 2022 онд 19 байршилд татмын ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийх газрыг сонгон авч, хашаалан хамгаалах ажлын даалгавруудыг боловсруулсан. Тус ажлын худалдан авах ажиллагааг зохион

байгуулах эрхийг БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 06 дугаар сарын 24-ний А/233 тоот тушаалаар Дорнод, Сүхбаатар, Ховд, Завхан аймгийн Засаг дарга нарт шилжүүлэн, Нээлттэй тендер шалгаруулалтыг 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2 удаа зарласан боловч тус сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлтээ ирүүлээгүй. Иймд үнийн өсөлт, бараа материалын хомсдолтой холбоотойгоор хашаалах талбайн хэмжээг 30 хүртэлх хувиар бууруулан, сонгон шалгаруулалтыг 2022 оны 09 дүгээр сарын 13-наас дахин зарласан. Ойжуулалт хийх талбайг хашаалан хамгаалах ажлын сонгон шалгаруулалтыг 09 дүгээр сард багтаан эцэслэж, 10 дугаар сард багтаан хашаалах ажлыг гүйцэтгүүлсэн. Хашаалан хамгаалах ажлыг төслийн санхүүжилтээр, бусад зардлыг орон нутгаас хариуцан ажилласан. Ховд аймагт 10 байршилд 60.8 га, Дорнод аймагт 4 байршилд 14 га, Завхан аймагт 3 байршилд 24 га, Сүхбаатар аймагт нэг байршилд 8 га буюу нийт 106,8 га газарт ойжуулалт хийх талбайг хашаалан хамгаалах ажлыг гэрээт байгууллагууд гүйцэтгэсэн ба тус хашаалсан газарт ирэх жилд нийт 53'000 мод тарих боломж бүрдээд байна. Үр дүн:

1. Завхан, Ховд, Дорнод, Сүхбаатар аймгийн хэмжээнд 19 байршилд 100 га-аас багагүй талбайд татмын ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын ажил бэлтгэл ажил бүрэн хийгдсэн байна.
2. Эдгээр байршлуудад голын татмын хөрс, ургамлын доройтлын түвшин буурч, ус барих чадвар нэмэгдэнэ.

2.2-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо: 2

Гүйцэтгэлийн хувь 70%

Үйл ажиллагаа 2.3: Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшигт үзэгдлээс болсон амьжиргааны тогтворгүй байдлыг багасгах зорилгоор хадлангийн болон нөөц бэлчээрийн газар хамгаалах, нөхөн сэргээх, аюулгүй нөөцийн тэжээлийн агуулах, өвсний саравч барих

2.3.1. Бэлчээр, хадлангийн газар хамгаалах, хаших, онцгой байдлын үед ашиглах тэжээлийн байгууламж барих, булаг хаших, голын сав газарт ойн нөхөн сэргээлтийн арга хэмжээний бэлтгэл ажлыг хэрэгжүүлэх

Ажлын биелэлт: Дээрх ажлын хүрээнд сайн туршлага, боломжит технологийн арга аргачлал, орон зайн мэдээлэл, бодит судалгаан дээр үндэслэн 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төсөл хэрэгжих нийт хугацаанд авч хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн ажлуудын байршлыг тодорхой болгосон. Тус ажлын сонгон шалгаруулалтад ЖЕМР ХХК шалгарч, зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулж гэрээт ажил хийгдсэн. Үүнд дараах ажлууд хийгдсэн.

- Татмын шүгүйн ойжуулалт хийх тохиромжтой байршлын үнэлгээнд газарзүйн мэдээллийн систем дээр суурилсан олон шалгуурт шийдвэр гаргалтын аргыг эрэмбэлэгчийн матрицын аргатай хослуулан ашигласан гаргасан
- Хөв цөөрөм байгуулах талбайг сонгохдоо “Монгол орны тохиромжтой байдлын үнэлгээний аргачлал”-ыг ГХГЗЗГ-ын мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 08 сарын 30-ны өдрийн А/20 тоот тушаалын 9-р хавсралтаар (хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга зүй, шалгуур үзүүлэлт) баталсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн “Инж ГеоТех” ХХК-ийн үр дүнд тулгуурлан гаргасан.
- Бэлчээр хамгааллын талаар: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ)-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар Монгол орны бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүдийг баталсан байдаг. Уг хавсралт болон 2016 онд “Инжгеотех ХХК”-аас гаргасан таван төрлийн малын тохиромжтой бэлчээр нутгийг дулаан, сэрүүний улирлаар үнэлсэн тайланд үндэслэн Монгол орны бэлчээрийн нөөц бүхий газрыг дахин тооцоолохгүйгээр тухайн үр дүнг газар ашиглалтын байдлын 2022 оны мэдээллээр шинэчлэн үнэлж бэлчээрийн бус газрыг зураглаж (МОДИС хиймэл дагуулын мэдээгээр тооцоолсон ургамалжилтын индекс, ууршилт, газрын гадаргын температурын 22 жилийн мэдээг олон шалгуурт шинжлэлийн аргаар шинжиж олон жилийн дундаж үзүүлэлтээс $\pm 1\sigma$ -аас ихээр олон жил хазайсан буюу өөрчлөлттэй гэж гарсан бэлчээр нутгийг ялгаж ургамлын биомасс багатай газраас эхлэн хамгаалах арга хэмжээ авах дарааллыг тодорхойлж зурагласан.
- Тэжээлийн агуулах, өвсний саравч: Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн эрсдэлтэй үед хэрэг болох малын тэжээлийн агуулах, өвсний саравч сум бүрд байвал зохино гэдэг байдлаар хандаж сумдын уур амьсгал, ургамалжилтын нөхцөл, өөрчлөлтийн суурь үзүүлэлт дээр нэмж том малын зүй бусын хорогдол, хүн ам, малчин өрх, малчдын тоо, сумдад тэжээлийн агуулах байгаа эсэх зэрэг үзүүлэлтүүдийг шалгуур болгож сумдыг эрэмбэлсэн. Тэжээлийн агуулахгүй, зудын давтагдал, малын зүй бусын хорогдол ихтэй, уур амьсгал, ургамалжилтын нөхцөл муу, өөрчлөлт ихтэй сумдад тэжээлийн агуулах, өвсний саравчийг тэргүүн ээлжид байгуулах нь зүйтэй гэсэн хандлагаар эрэмбэ тогтоосон.

2022 оны арван нэгдүгээр сарын байдлаар дасан зохицох арга хэмжээний төрөл тус бүрийн чанарын үзүүлэлт, үндсэн үр дүн, хэрэгжих газар, байгаль орчны нөхцөл байдлыг харуулсан мэдээллийн хуудсыг тодорхойлж, 2022-2027 онд хэрэгжүүлэх

дасан зохицох арга хэмжээний төлөвлөгөөний саналыг боловсруулсан.

Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн хэмжээнд ой, ус, газрын (бэлчээр, хадлан) нөөцийн менежмент буюу татмын ойн нөхөн сэргээлт, булаг хаших, хадлан, бэлчээрийн нөөц газрыг хамгаалах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах болон онцгой байдлын үед ашиглах тэжээлийн нөөцийн агуулах болон өвсний саравч барих арга хэмжээг хэрэгжүүлэх газрын сонголтыг орон зайн дүн шинжилгээ болон хээрийн судалгаагаар баталгаажуулан тогтоож, арга хэмжээ тус бүрээр боломжит байршлуудын судалгаа гарсан.

2.3.2. Зорилтот 4 аймгийн хэмжээнд онцгой байдлын үед ашиглах өвс тэжээлийн агуулах барих

Ажлын биелэлт: Онцгой үед хэрэглэх өвс, тэжээлийн агуулах барьж байгуулах нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшигт үзэгдлийн улмаас малчдад үүсэж болзошгүй бодит эрсдэлийг бууруулах ач холбогдолтой. Зорилтот 4 аймгийн Онцгой байдлын газраас авсан эрсдэл үүсэж болзошгүй, өвс тэжээлийн нөөц агуулах хангалтгүй сумдын судалгааг авч, байршлын сонголт хийсэн. 2022 онд Ховд аймгийн Үенч сум, Завхан аймгийн Отгон сум, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум, Дорнод аймгийн Матад суманд тус тус онцгой үед хэрэглэх өвс, тэжээлийн агуулахын цогцолборыг барилга угсралтын мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн. 2022 оны худалдан авах ажлын төлөвлөгөөнд 1 багц ажил байсныг Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотойгоор аймаг тус бүрээр, зураг төсвийн ажлыг тусад нь салган нийт 5 ажил болгох саналыг төслийн Удирдах хорооны 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.Өвс, тэжээлийн агуулах барих ажлын зураг төсөв нь 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр батлагдаж, худалдан авалтын ажиллагааг эхлүүлсэн. Ховд аймгийн Үенч сумын агуулах барих ажилд “Очир буян өргөө” ХХК 10 дугаар сарын 07-нд, Завхан аймгийн Отгон сумын агуулах барих ажилд “Тэсийн бүрд” ХХК 10 дугаар сарын 17-ны өдөр тус тус шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.Байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж хүйтний улиралд барилга угсралтын ажил гүйцэтгэх нь барилгын чанарт нөлөөлж болзошгүй тул учирчболзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажил гүйцэтгэх гэрээг 2023 онд хийж дуусахаар сунгасан. Сүхбаатар, Дорнод аймагт өвс, тэжээлийн саравч барих ажлын сонгон шалгаруулалт хийгдэж гэрээ байгуулсан. Гэрээт ажил 2023 онд 6 сард хийгдэж дуусна.

2.2 хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо: 2

Гүйцэтгэлийн хувь 70%

Үйл ажиллагаа 2.4: Булаг хамгаалах, шинэ худаг гаргах, худаг сэргээх, ус хураах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар усны хүртээмжийг нэмэгдүүлэх

2.4.1. Зорилтот 4 аймгийн хэмжээнд 8 булгийн эхийг хашиж хамгаалах

Ажлын биелэлт: Гол, булгийн эхийг хамгаалах замаар усны хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг тухайн бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнтэй нийцүүлэх, улмаар малчдын байгууллагад хариуцуулах хамгаалах зохион байгуулалтыг жишиг байдлаар хөгжүүлнэ. Зорилтот аймаг тус бүрд хашиж хамгаалах шаардлагатай байгаа 2 булгийн байршлыг тогтоож, хашаалах талбайн хэмжээг гаргасан. Гэвч аймаг бүрд 2 булгийн эхийг хашиж хамгаалах ажил нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан бараа материалын үнийн өсөлт, хомсдолтой холбоотойгоор зах зээлийн бодит өртөг нэгж тутамд анх төлөвлөснөөс (2018 онд төслийн баримт бичигт тусгагдсанаас хойш) даруй 3 дахин нэмэгдээд байна. Иймд, төслийн 2022 оны худалдан авалтын ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, үнийн дүнг нэгж тутамд 1'000 ам.доллар байсныг 3'000 ам.доллар болгох саналыг 2022 оны 08 дугаар сарын 05-ны төслийн Удирдах хороогоор хэлэлцүүлэн батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Булгийн эхийг хамгаалах, шинэ худаг гаргах, худаг сэргээн засварлах, гадаргын усыг хуримтлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар усны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөн Ховд, Дорнод, Сүхбаатар аймгуудад 6 булгийн эхийг хашиж хамгаалсан. Булгийн эхийг хамгаалснаар булгийн ундарга, усны нөөц, хангамж нэмэгдсэнээр 2022 онд хашиж хамгаалж буй 6 булгаас ундаалдаг 270 гаруй малчин өрх болон 180.0 мянга гаруй малын ундны усны эх үүсвэрийг хатаж ширгэхээс сэргийлээд байна.

2.4.2. Төслийн 4 аймгийн хэмжээнд бага оврын хөв, цөөрөм барих ажлын тооцоо судалгаа, зураглал гаргах

Ажлын биелэлт: Хөв, цөөрөм байгуулах ажлыг тухайн бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнтэй нийцүүлэх, улмаар малчдын байгууллагыг жишиг байдлаар хөгжүүлэх ажилтай уялдуулах, аймаг, сумын газар ашиглалтын болон Усны нөөцийн нэгдсэн менежмент төлөвлөгөө (УННМТ)-нд суурилан гүйцэтгэнэ. Судалгааны дүнд хөв, цөөрмийг байгуулах арга технологи нэвтрүүлэх судалгаа, зураг төсөл, тооцоо хийгдсэн. Хөв цөөрөм байгуулах тохиромжтой байршлуудыг холбогдох усны сав газруудын УННМТ болон аймаг сумдын ГЗБЕТ-нд тусгагдсан саналуудаас авч нэгтгэсэн. Мөн 2016 онд Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газраас гаргасан хөв цөөрөм байгуулахад

тохиромжтой байршлын судалгаанаас зорилтот 4 аймгийн хэмжээнд тодорхойлогдсон 150 орчим байршлуудыг авсан. Эдгээр байршлуудыг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх тохиромжтой байдлын судалгаагаар нийт 13 шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэн эрэмбэлж, аймаг бүрд хамгийн ач холбогдол бүхий эхний 3 байршлыг тодорхойлон гаргасан. Судалгааны үр дүнд тулгуурлан 2022 онд Ховд, Завханд тус бүр 3 байршилд хөв цөөрмийн зураг төсөв хийж, Дорнод, Сүхбаатар аймгуудад 2023 онд илүү нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй гэж үзсэн. Тус ажлын даалгавар 07 дугаар сард батлагдаж, БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 07 дугаар сарын 20-ны А/278 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо ажил гүйцэтгэх багийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Дэлгэрэнгүй жагсаалтад орсон оролцогчоос гаргасан гомдлыг Сангийн яаманд хянасан. 2022.12.20-ны өдөр тендерийн саналыг нээнэ.

Гарах үр дүн: Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан учирч болзошгүй байгалийн гамшигт үзэгдэл, урт удаан хугацааны хуурайшилтын үед хүн, малын усны хомсдолд орох эрсдэлээс сэргийлнэ. Тухайн бүс нутгийн бичил уур амьсгал, экологийн тэнцвэрийг тогтворжуулахад эерэг нөлөө үзүүлнэ. Хөв цөөрөм байгуулсан газар нутгийн худаг, гол, горхи, нуурын усны нөөцөд учирч болзошгүй хэт ачааллыг бууруулна.

2.4.3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний хүрээнд Дорнод, Сүхбаатар аймагт газрын доорх усыг хуримтлуулах далд систем барьж байгуулах судалгаа, тооцоо хийх

Ажлын биелэлт: Дорнод, Сүхбаатар аймгийн ууршилт өндөртэй бүс нутгуудад ил задгай цөөрөм байгуулах нь ууршилтаар их хэмжээний ус алдах сул талтай. Иймд тус бүс нутгуудад газрын доорх усны ордын усны нөөцийг арвижуулах, арга технологи нэвтрүүлэх судалгаа, зураг төслийг боловсруулна. Энэ ажил нь цаг хугацаа, хөрөнгө их шаарддаг тул дээрх 2 аймгийн аль тохиромжтой байршилд 1 цэгийг сонгон авах нь илүү үр дүнтэй гэж урьдчилсан байдлаар тооцоо гараад байна. Тус ажлын даалгавар 07 дугаар сард батлагдаж, БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 07 дугаар сарын 27-ны А/302 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо ажил гүйцэтгэх багийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Хураангуй жагсаалт үүссэн, тендер 2023 оны 01 дүгээр сарын 04-ны өдөр нээнэ.

Гарах үр дүн: Хуурайшилт ихтэй, газрын гадаргын усны ууршилт өндөртэй байдаг эдгээр аймгуудад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ирээдүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс газрын доорх усны хуримтлалыг үүсгэн усны нөөцийг арвижуулах замаар хүн ам, хөдөө аж ахуй, цаашлаад үйлдвэрийн усан хангамжид ашиглах боломж бүрдэнэ. Тухайн бүс нутгийн усны нөөцөд учирч болзошгүй хэт ачааллыг бууруулна.

		<p>2.3-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо: 3</p> <p>Гүйцэтгэлийн хувь:50%</p>
	<p>Бүрэлдэхүүн хэсэг: 3</p> <p>Гарал үүсэл нь тодорхой, уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх малчдын чадавхыг нэмэгдүүлж, бэхжүүлэх</p> <p>2022 оны зорилт:</p> <p>Төсөлтэй хамтран ажиллах малчдын үйлдвэрлэгч байгууллагын бэлэн байдлын судалгаа, зах зээлийн шинжилгээ хийх, зарим шинэлэг төслүүдийг туршилтаар хэрэгжүүлэх. Төр, хувийн хэвшил, малчдын үйлдвэрлэгч байгууллага, малчдын түншлэлийн судалгаа хийх, зохистойгоор хөгжүүлэх хувилбар боловсруулна</p>	<p>Тайлант хугацаанд бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.</p> <p>Үйл ажиллагаа 3.1: Гарал үүсэл нь тодорхой, уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжсэн төр, хувийн хэвшил, нөхөрлөлийн түншлэлийг хөгжүүлэх</p> <p><u>3.1.1."Хариуцлагатай нүүдэлчин" стандартын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх</u></p> <p>Ажлын биелэлт: Малчдын уламжлалт арга ажиллагааг орчин цагийн органик үйлдвэрлэл болон мал амьтны тавлаг байдалтай уялдуулан боловсруулсан "MNS 6891:2020- Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага" стандартыг сурталчлан ажлын хүрээнд Монгол орны бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхэд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалж, тавлаг байдлыг хангах, байгаль орчин, бэлчээр, тэжээл усны хангамжийг зөв зохистой ашиглах, малын үржил селект, тэжээллэг, арчилгаа, маллагаа зэрэг үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэхэд тавигдах шаардлагуудыг таниулах зорилготой. Энэ ажил Дорнод, Сүхбаатар аймагт хэрэгжсэн. Энэ ажлын гүйцэтгэгчээр "Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо" ТББ шалгарч 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Дорнод, Сүхбаатар аймгаас тус бүр 5 суманд төслийн зорилготой уялдуулан тодорхой шалгуур үзүүлэлтүүд болон төслийн удирдах нэгж, орон нутгийн саналыг үндэслэн сонгож малчид, удирдлага, мэргэжилтнүүд, малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх үйл ажиллагаанд оролцдог үйлдвэрлэгч этгээд, ААН-үүдийн төлөөллийг оролцуулан нийт 400-500 оролцогчдод (үүнээс 400 малчин) "ММ5 6891:2020 стандартыг сурталчлан таниулах ажлыг хийсэн. MNS 6891:2020 Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага" стандартыг төслийн зорилтот аймаг сумдын ХАА, мал эмнэлгийн мэргэжилтнүүд, малчид, бэлтгэн нийлүүлэгчдэд сурталчлан таниулсан. Мөн стандартыг нэвтрүүлэхэд тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал, зөвлөмж боловсруулсан.</p> <p><u>3.1.2. Үйл ажиллагаа нь тогтворжсон малчдын хоршоонд түлгүүрлан малын гаралтай түүхий эдийг боловсруулах, шинэ бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх туршилтын ажлын цахим систем болон мал эмнэлгийн эрүүл ахуйн шаардлага хангахад дэмжлэг үзүүлэх (сарлагийн борц, сүү сүүн бүтээгдэхүүн)</u></p>

Хүрэх үр дүн:

Малчид УАӨ-д тэсвэртэй мал сүрэгтэй болох, гарал үүсэл нь тодорхой, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд харьцангуй өндөр үнэтэй нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Ажлын биелэлт: Үйл ажиллагаа нь тогтворжсон малчдын хоршоонд тулгуурлан малын гаралтай түүхий эдийг боловсруулах, шинэ бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх туршилтын ажлын цахим систем болон мал эмнэлгийн эрүүл ахуйн шаардлага хангахад дэмжлэг үзүүлэх (сарлагийн борц, сүү сүүн бүтээгдэхүүн) ажлын даалгаврын боловсруулж НҮБХХ-өөс зарлаж зөвлөхийг сонгон шалгаруулсан. 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдөр хувь зөвлөх З.Цэрэнхандтай гэрээ байгуулж эхлэлийн тайланг хүлээн авсан. Ховд аймгийн Дуут сумын Шивэр багт орон нутгийн малчдын хоршоодын санаачилгад тулгуурлан сарлагийн борц (сарлагийн хатаасан мах) үйлдвэрлэх, сүү, сүүн бүтээгдэхүүнийг уламжлалт аргаар малын гаралтай бүтээгдэхүүнээр төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой хийгдэж байна. Хэрэгжүүлснээр дараах үр дүнг хүлээж байна. Үүнд:

1. Ган, зуд зэрэг цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлыг үл харгалзан жилийн дөрвөн улиралд уламжлалт арга, технологиор тасралтгүй сарлагийн борц үйлдвэрлэхэд мэргэжлийн заавар, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.
2. Зах зээлийг нэмэгдүүлэх зорилгоор сарлагийн борцыг лабораторийн шинжилгээнд хамруулж найрлагыг нь тодорхойлно.
3. Орлогыг нэмэгдүүлэхийн тулд уламжлалт сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
4. Сарлагийн ааруул, цөцгий, сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах цэг байгуулах талаар зөвлөнө.

3.1.3. Байгаль орчин, нийгмийн менежментийн хамрах хүрээг сайжруулж, нутгийн уугуул иргэдтэй ажиллах төлөвлөгөө, хамгааллын менежментийн төлөвлөгөө боловсруулах

Ажлын биелэлт: Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах байгаль орчин, нийгмийн менежментийн хамрах хүрээ, нутгийн уугуул иргэдтэй ажиллах төлөвлөгөө, хамгаалалтын төлөвлөгөөг НҮБХХ болон донорын журмын дагуу төлөвлөж, хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн. Монгол Улсын хууль тогтоомж, НҮБХХ-ийн Нийгэм, Хүрээлэн буй орчны Стандарт, Уур Амьсгалын Ногоон Сангийн Байгаль орчин, нийгмийн бодлогын хүрээнд Байгаль орчин, нийгмийн менежментийн хамрах хүрээ, Хамгааллын төлөвлөгөө, Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Нутгийн иргэдтэй хамтран ажиллах төлөвлөгөө, Оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэгч гүйцэтгэхээр "Би Жи Эм Дистрибьшн" ХХК шалгарч 2022 оны 10 дугаар сарын 14-нээс ажлыг эхлүүлсэн. Ажил гүйцэтгэх хуваарийн дагуу зөвлөх үйлчилгээний эхлэлийн тайлангаа ирүүлсэн. Тус ажлын үр дүнд төслийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжих аливаа үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчин, нийгмийн аливаа нөлөөлөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, үүссэн нөлөөллийг бууруулах боломж бүрдэнэ.

3.1.5. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдсэн малчдын амьдралын нөхцөл байдлын судалгаа хийх зөвлөх үйлчилгээ

Ажлын биелэлт: 2022 оны ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу ажлын даалгаврыг боловсруулж зөвлөхийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж хувь зөвлөх Начины Баатарбилэгтэй 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдөр гэрээ байгуулсан. Зөвлөх эхлэлийн тайлангаа ирүүлээд ТАН-ээс хянаж баталгаажуулаад байна. Эцсийн тайлангийн хугацаа 2023 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр байна. Үүний үр дүнд зорилтот 2 аймагт (Сүхбаатар, Дорнод) уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэн малчдын амьжиргаа, амьдралын нөхцөл байдлын судалгаа хийж, зөвлөмж боловсруулна. Жендэрийн мэдрэмжтэй амьжиргааг төрөлжүүлэх арга барил болон малчдын үйлдвэрлэгч байгууллагын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг боловсруулна.

2021 оны ажлын төлөвлөгөөний 3.1.6. Нотлох баримтад суурилсан ноолуур бэлтгэлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх үүднээс Дорнод аймгийн хэмжээнд ноолуур бэлтгэлийн үнэлгээг малчдын оролцоотой гүйцэтгэж, нарийвчилсан зөвлөмж бүхий малчдын хүйсийн тэгш оролцоог хангах стратеги боловсруулах

Ажлын биелэлт: Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн ТББ (SPDRI NGO) уг зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан. Зөвлөх баг нь Ноолуурын салбарын жендэрийн дүн шинжилгээ, Ноолуурын үйлдвэрлэлд жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратегийн төлөвлөгөөг боловсруулж хэлэлцүүлэг зохион байгуулж, талуудаас санал авсан. Нотлох баримтад суурилсан ноолуур бэлтгэлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх үүднээс Дорнод аймгийн хэмжээнд ноолуур бэлтгэлийн үнэлгээг малчдын оролцоотой гүйцэтгэж, нарийвчилсан зөвлөмж бүхий малчдын тэгш оролцоог хангах стратеги боловсруулагдсан. Мөн Энэ хүрээнд зөвлөх баг нь ноолуурын салбарын жендэрийн дүн шинжилгээ, ноолуурын үйлдвэрлэлд жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратегийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлсэн. Сүүлийн жилүүдэд дунджаар 10 орчим мянган тонн ноолуур бэлтгэж, ноолуурын экспортын 65 орчим хувийг угаасан ноолуур, 20 хүрэхгүй хувийг гүн боловсруулсан бүтээгдэхүүн эзэлж байна. ҮСХ-ны 2021 оны мэдээллээр 298.8 мянган малчин бүртгэлтэй, 2019 оны мэдээллээр, малчдын 58.3 хувь нь эрэгтэй, 41.7 хувь нь эмэгтэй байна. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын дунд эмэгтэй өмчлөгч, удирдлага давамгайлж байгаа бөгөөд тэр дундаа бичил, жижиг, дунд үйлдвэрлэгчдийн дунд эмэгтэйчүүд зонхилж байна. Энэ байдлаараа ноолуурын боловсруулах салбарыг “эмэгтэй бизнес”-ийн төрөлд багтаж болох бөгөөд экспортод гүн боловсруулсан бүтээгдэхүүнийг гаргахад чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй цогц арга хэмжээг бизнес эрхлэгч эмэгтэй, эрэгтэйчүүд хийгээд ажилчдын дуу

хоолой оролцоотойгоор төлөвлөж хэрэгжүүлэх шаардлага дэвшигдэж байна.

3.1 хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо: 4

Гүйцэтгэлийн хувь:70%

2021 оны ажлын төлөвлөгөөний 3.2.1. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, бүрэлдэхүүн хэсгүүдийн ажлын явцад малчин өрх болон малчдын амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний аргазүйг боловсруулах

Энэ ажлын хүрээнд төслийн үйл ажиллагааны явцад болон төгсгөлд хөдөөгийн иргэд, малчдын амьдралд гарч буй өөрчлөлт, үр дүнг тодорхойлох төслийн нөлөөллийн үнэлгээг хийх судалгааны аргазүй, зөвлөмж боловсруулах ажлыг ТХН нь олон улсын хэмжээний болон дотоодын зөвлөхүүдтэй хамтран гүйцэтгэхээр төлөвлөсөн. Судалгааны арга зүйг боловсруулахдаа төсөл хэрэгжих Дорнод, Сүхбаатар, Завхан, Ховд аймгуудыг хамарна. Энэхүү ажлын хүрээнд төслийн үйл ажиллагааны хяналт, шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт болон судалгааны үнэлгээний аргазүйн нийцэл, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж боловсруулахаар төлөвлөж байна.

Ажлын биелэлт: Зөвлөх сонгон шалгаруулалтад гадаадын этгээдийн оролцоог хангахын тулд дахин ажлын хэсэг байгуулж ажиллахыг БОАЖЯ-наас шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотой БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01-р сарын 04-ний өдрийн А/01 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан боловч уг ажлыг НҮБХХ рүү шилжүүлж 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр зөвлөхийн зарыг нийтэлсэн. Олон улсын Зөвлөхөөр Каруна Кришнасвами, дотоодын зөвлөхөөр М.Алтансүх нар шалгарч гэрээг 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан. Уг ажлын хүрээнд төслийн эхлэлийн, явцын, болон төгсгөлийн шатны нөлөөллийг бүрэн үнэлэх судалгааны арга зүй боловсруулж судалгааг хэрхэн зохион байгуулах, мэдээллийг дүн шинжилгээ хийх, судалгааны үр дүнд гарах тайлангийн агуулга зэрэгт зориулсан зөвлөмж гаргасан.

2021 оны ажлын төлөвлөгөөний 3.2.2. Гарал үүсэл нь тодорхой, УАӨ-д тэсвэртэй мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг (ноос ноолуур, арьс шир) цахим сан (Цахим ХАА)-д бүртгүүлэх замаар түүхий эдийн ханган нийлүүлэлт, мөшгөх тогтолцоог бий болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, малчдад сургалт өгөх

Ажлын биелэлт: Энэ ажлын гүйцэтгэгчээр “Дижиталмедик” ХХК шалгарч 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай 220505/06-235 дугаартай гэрээ байгуулан ажлаа хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд тогтвортой гарал үүсэлтэй, малын түүхий эд, бүтээгдэхүүнийг (ноос ноолуур, арьс шир) бүртгүүлэх цахим сан (Цахим ХАА)-г хөгжүүлсэн. Ховд, Завхан,

Дорнод, Сүхбаатар аймгийн малчид, малчдын бүлэг, хоршоод, сумдын малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх үйл ажиллагаанд оролцдог үйлдвэрлэгч этгээд, ААН-үүд болон худалдан авагч байгууллагуудын бүртгэл бий болгож түүхий эд худалдан авалтын өгөгдлийн үнэн бодит мэдээллийг ашиглах, үр дүнтэйгээр хуваарилах боломжийг бүрдүүлэхээр зорьж тус зорилтод аймгийн малчид, малчдын бүлэг, хоршоод, сумдын ХАА-н тасаг, мал эмнэлгийн мэргэжилтнүүд, багийн удирдлага, малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх үйл ажиллагаанд оролцдог үйлдвэрлэгч этгээд, ААН-үүдийг хамруулсан системийн нэвтрүүлэлт, сургалт зохион байгуулсан. Төр, хувийн хэвшил, иргэдийн байгууллагын түншлэлийг тодорхойлох, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний мөрдөх тогтолцоог сайжруулах, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх малчдын үйлдвэрлэгч байгууллагуудыг чадавхжуулах, уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих мэдлэгийн бүтээгдэхүүнийг бий болгох, түгээн дэлгэрүүлэх ажилд ахиц гарсан.

Хэрэгжүүлсэн ажлын тоо: 2

Гүйцэтгэлийн хувь: 70%

3.3.1. Малын гаралтай түүхий эдийн хадгалалт, борлуулалтын нэг цэгийн үйлчилгээг бий болгох (Завхан аймгийн Сантмаргац сум)

Ажлын биелэлт: Ажлын даалгаврын төслийг НҮБХХ-ийн загварын дагуу Англи хэлээр боловсруулсан. Гүйцэтгэгчийг сонгох тендерийг зарлаж материалыг хүлээн авсан. Төсөвт өртгөөс хэт илүү дүнтэй санал ирүүлсэн учраас сонгон шалгаруулах боломжгүй болсон тул дахин ажлын даалгаврыг боловсруулж сонгон шалгаруулалтыг зарласан. Сонгон шалгаруулалтын шатандаа байна. Тус ажир хийгдсэнээр малын гаралтай эслэг материалыг (ноос ноолуур, хялгас, хөөвөр, магадгүй өвлийн цагт арьс шир) стандартын дагуу бэлтгэх, хадгалах жишиг агуулах баригдсан байна.

3.3.2. Цахим хөдөө аж ахуй (e-agriculture) бодлогын хэрэгжилтийг дэмжих, мэдээллийг баазыг хөгжүүлэх ажлын хүрээнд “Ноос ноолуурын боловсруулах үйлдвэрийн түвшинд мөшгөх тогтолцоо хөгжүүлэх”

Ажлын биелэлт: Ажлын даалгаврын төслийг НҮБХХ-ийн загварын дагуу Англи хэлээр боловсруулж төслийн менежер, хөтөлбөрийн шинжээч нараар хянуулж бэлэн болгон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил явагдаж байна. Гол зорилго нь ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн боловсруулалтын шатанд “Мал аж ахуйн эслэг материалын нийлүүлэлтийг хянах” цахим системийг бий болгож, гарал үүсэл нь тодорхой түүхий эдийг хүлээн авч байгальд ээлтэй, хүний эрүүл мэндэд тустай аргаар боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг талаарх нотолгоог хэрэглэгчдэд хүргэх, хаяг

шошгод энэ чиглэлийн нэмэлт мэдээлэл оруулах, энэхүү цахим системийн талаар үйлдвэрийн ажилчдад сургалт зохион байгуулснаар чадавх бий болно.

Хэрэгжүүлсэн ажлын тоо: 2

Гүйцэтгэл: 30%

3.4. Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон, мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд хувийн хэвшлийн оролцоо, малчдын эрхийг хангах зорилгоор мэдлэгийн бүтээгдэхүүнийг бий болгож, түгээн дэлгэрүүлэх

3.4.1. Төслийн зорилтод 4 аймгийн малчдын байгууллагын нэмүү өртөгийн сүлжээг хөгжүүлэх

Ажлын биелэлт: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэхэд малчдын оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой эх үүсвэртэй, уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийг бий болгох, өргөжүүлэх зорилгоор сонгогдсон 24 сумын малчдын үйлдвэрлэгч байгууллагуудын дунд төсөл сонгон шалгаруулах ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл зарласан. Малчид, малчдын үйлдвэрлэгч байгууллагуудын төлөөлөлд төслийн санал хүлээн авах маягт бөглөх, илгээх заавар болон мэдээлэл хүргэх цахим сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Төслийн аймаг, суманд үйл ажиллагаа явуулж буй малчдын үйлдвэрлэгч байгууллагын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэхэд малчдын оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой эх үүсвэртэй, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийг бий болгох, өргөжүүлэх зорилгоор нийт 73 малчны байгууллага төслийн санал ирүүлсэн. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 8 төслийг эхний шатанд сонгосон судалгааг хийж байна. Тус үйл ажиллагааны үр дүнд малчдын байгууллагын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийг даван туулах чадавхтай болгох зорилгоор бэлчээрийн даацад тохирсон мал аж ахуй эрхлэх санал санаачилга, мах, сүү, ноос, ноолуур, арьс шир зэрэг бүтээгдэхүүний боловсруулалтыг дэмжиж, мал аж ахуйн гаралтай байгальд ээлтэй, “Хариуцлагатай нүүдэлчин” стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, савлах, хадгалах, маркетинг хөгжүүлэх, мөшгөх системийг нэвтрүүлэх, ашиглах боломж бүрдэнэ.

3.4.2. Төслийн зорилтод 4 аймгийн малчдын байгууллагын нэмүү өртөгийн сүлжээг хөгжүүлэх

Ажлын биелэлт: Зорилтод 4 аймагт баталгаажсан үүлдэр, омгийн стандартад нийцсэн үржлийн малын цөм сүргийг бий болгож, цөм сүргийн үйлчилгээний нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын дунд сонгон

		<p>шалгаруулалтыг зохион байгуулж байна. Тус ажлын хийснээр дараах үр дүнг гарна.</p> <ul style="list-style-type: none"> • Аймаг, сумын түвшний мал үржлийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлно. • Ховд аймагт бүртгэлтэй гэрчилгээжсэн үүлдэр, омгийн стандарт хангасан үржлийн малын цөм сүрэг бүрдүүлж, сонгогдсон сумын мал үржлийн үйлчилгээний нэгжид шилжүүлнэ. • Сонгогдсон цөм сүргийн үйлчилгээний хувийн нэгжийг шаардлагатай багаж, хэрэгслээр хангах, малын үржил болон биотехнологийн чиглэлээр сургалт явуулна. • Сурсан сургамж, мэдлэгийг бусад сумдад түгээх талаарх зөвлөмж гарна. <p>Хэрэгжүүлсэн ажлын тоо: 2</p> <p>Гүйцэтгэл: 30%</p>
8.	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<ul style="list-style-type: none"> • Дэлхийн нийтээр тархсан COVID-19 цар тахлын цар тахлын дэгдэлтийн цар хүрээ буурахгүй, үүнтэй холбоотойгоор эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй болж бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт зэрэг нь төслийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц нөлөө үзүүлсэн байгаа хэдий ч төслийн хэрэгжилт ерөнхийдөө амжилттай явагдаж байна. Төслийн 2022 оны төлөвлөсөн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 удаа шинэчлэн баталсан. 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг төслийн баримт бичиг, төсөл хэрэгжүүлэгч түншүүд, тухайлбал БОАЖЯ, ХХААХҮЯ, ОБЕГ болон орон нутгийн аймгуудын төлөөлөлтэй хийсэн өргөн хэлэлцүүлэгт үндэслэн 2022 оны төсөвт тусгагдсан төсөвтэй уялдуулан 2022 оны 05 дүгээр сарын 24 -ны өдрийн ТУХ-ын хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэн батлуулсан. УАНС-тай байгуулсан гэрээнд тусгагдсаны дагуу Хариуцагч талуудтай (ХХААХҮЯ, ОБЕГ, ЦУОШГ) гэрээ байгуулах, төсөлд хамрагдаж байгаа аймгуудыг Хариуцагч тал болгон нэмэх, гэрээ байгуулах, гэрээнд орон нутгийн хамтын санхүүжилтийг тусгах, орон нутагт худалдан авах ажиллагааны эрх шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн. • Монгол улсын Засгийн газраас төсвийн хэмнэлтийн хууль шинээр баталж хэрэгжүүлсэн холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан аудио, видео, болон хэвлэмэл бүтээгдэхүүн хийлгэх 6 төрлийн ажлыг хариуцан гүйцэтгэх байгууллагаар БОАЖЯ байсныг НҮБХХ болгон өөрчилж, үнийн өсөлттэй холбоотойгоор өвс, тэжээлийн агуулах барьж байгуулах нэгж төсвийг ижил төстэй ажлуудын жишиг өртгийг харгалзан 78 саяас 150 сая болгон өөрчлөн ТУХ-оор

хэлэлцүүлэн батлуулж худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулсан.

- Төсөл хэрэгжих өнгөрсөн хугацаанд хамтын санхүүжилт, хариуцагч талуудын хариуцлага, оролцоо нь төслийн ажлын төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд нэн чухал тул энэ онд бид төсөл хэрэгжиж буй дөрвөн аймгийн ЗДТГ-ыг төслийн хариуцагч тал болгон өөрчилж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай хамтран ажиллах гэрээ байгуулснаар тухайн орон нутагт гүйцэтгэх худалдан авалт, хариуцан гүйцэтгэх ажлын чанар, биелэлт, хяналтын тогтолцоогоо баталгаажуулсан.
- Хамтын санхүүжилтийн механизмыг бий болгон, төслийн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтэд орон нутгийн төсвөөс 30 хувийг гаргах болсноор худалдан авах ажлын чанар, гүйцэтгэл, хяналтыг сайжруулах боломжийг бий болгосон.
- Төслийн батлагдсан баримт бичиг, Засгийн газрын хэрэгжүүлэгч талын хувьд хүлээсэн үүргийн дагуу төслийн үйл ажиллагаанд зарцуулсан хамтын санхүүжилтийн дүн ба явцыг БОАЖЯ, ХХААХҮЯ болон ОБЕГ-аас албан бичгээр шаардлагатай хугацаанд нь баталгаажуулан төслийг санхүүжүүлэгч байгууллага Уур амьсгалын ногоон санд хүргүүлсэн.
- Зорилтот аймгуудын уур амьсгалын өөрчлөлт, эмзэг байдлын шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээнд үндэслэн сүүлийн 12 сарын хугацаанд төсөл нь дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх газар сонгох шалгуураа боловсруулж чадсан. Энэ нь дасан зохицох арга хэмжээ авахаас өмнө хийх шаардлагатай томоохон судалгаа байв. Өөр нэг гол урьдчилсан нөхцөл болох одоо байгаа малчны байгууллагын олон нийтийн байгууллагуудын зураглалыг малчны оролцоотойгоор гаргаж, үнэлгээ өгөх судалгааны ажлыг хийсэн нь орон нутгийн түвшинд хийгддэг сайн туршлага дээр үндэслэн байгуулагддаг гэрээний шинэчилсэн загварыг боловсруулж, бэлчээр, усны нөөцийг хамгаалах, дундын нөөцийг тогтвортой удирдан зохион байгуулахад шаардлагатай хамтран ажиллах арга механизм бий болгох ажлын эхлэлийг тавилаа. Уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн болон ирээдүйн хандлагын мэдээлэлд тулгуурлан орон нутгийн эдийн засгийн голлох салбаруудын төлөвлөлтийг туршилтын байдлаар төслийн зорилтот аймгуудад хийж байна.
- Аймаг, сумын эдийн засаг, байгаль орчин, нийгмийн салбарын эмзэг эрсдэлтэй байдлыг шинжилж, цаашид хэрхэн, ямар чиглэлээр хөгжихийг систем динамикийн аргаар тооцож байна. Судалгаанд АНР аргачлалыг ашиглаад төслийн зорилтот аймгуудад малын гаралтай түүхий эдийг

боловсруулах үйлдвэрлэлийг аль суманд байгуулах нь тохиромжтой болохыг малын тоо, дэд бүтэц, ажиллах хүч, бэлчээрийн хүрэлцээ зэрэг шалгуур үзүүлэлтүүдээр жигнэж, загварчлалыг боловсруулж байна. Төслийн хүрээнд гүйцэтгэх байгалийн нөөцөөс хамааралтай хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг дээшлүүлэх болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг төрийн бодлого, хөтөлбөрүүдийн үзэл санаа, орчин үеийн техник, технологийн дэвшил, шинжлэх ухааны арга арга зүй, олон улсын болон үндэсний стандарт шаардлагад нийцүүлэн, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн өндөр үр ашигтай, тогтвортой үр нөлөө үзүүлэхүйц, ногоон хөгжлийн зарчимд нийцсэн байдлаар хэрэгжүүлэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөмж өгч ажиллах Техникийн ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачид, эрдэм шинжилгээний ажилтнууд, хувийн хэвшил зэрэг салбарын төлөөлөл ажиллаж байгаа бөгөөд 2022 онд Техникийн ажлын хэсгийн хурлыг танхим болон цахим хэлбэрээр 5 удаа зохион байгуулж санал зөвлөмжийг авч ажилласан.

- 2022 онд төслийн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн уулзалт, хэлэлцүүлэгт нийт 1800 оролцогч оролцсон. Үүнд: Төслийн оролцогч талуудын оролцоог сайжруулах ажлын хүрээнд хамтран хэрэгжүүлэгч гол байгууллагуудтай хэлэлцүүлэг 5 удаа зохион байгуулж 80 гаруй оролцогч оролцож энэ уулзалтаар гарсан саналыг төслийн хэрэгжилтийн явцыг сайжруулах болон цаашид хийх үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган ажиллаж байна.
- Мөн төслийн хүрээнд хийгдэж байгаа судалгаа, санал, зөвлөмж боловсруулж байгаа 28 зөвлөх ажилд зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийн 15 удаа зохион байгуулж нийт 220 гаруй оролцогч оролцсон.
- Түүнчлэн Уур амьсгалын эрсдэлийн мэдээлэлд суурилсан төлөвлөлт, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилан таамаглах (IBF), таамаглалд суурилсан санхүүжилт (FBF) зэрэг аргачлалуудыг боловсруулж төслийн хүрээнд 37 сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө, усны нөөцийн нэгдсэн менежментийн 8 төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ, дасан зохицох арга хэмжээг тусган шинэчлэн боловсруулж байна.
- Дасан зохицох арга хэмжээний хүрээнд нийт 106,8 га газрыг ойжуулалт хийх зорилгоор хашаалан хамгаалж, 70'000 тайраадасыг намрын тариалалтаар суулгасан. Үлдсэн талбайд ирэх хаврын тариалалтаар 50'000-аас багагүй мод тарих боломжийг бий болгов. Мөн 6 булгийг хамгаалснаар

270 гаруй малчин өрх болон 180 мянга орчим малын ундны усны эхийг хатаж ширгэхээс сэргийлсэн. Ховд, Завхан аймгуудад тус бүр 50 тн багтаамжтай тэжээлийн агуулах, 100 тн багтаамжтай өвс саравч барьж байгаа бөгөөд энэ нь тус аймгуудад зудын эрсдэлээс 357.8 мянган малыг хамгаалах боломжийг бүрдүүлж байна.

- Төслийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг 2 удаа хийж нийт 20 ажилтан оролцсон. Мөн төслийн зорилтод аймгуудад нийт 20 удаагийн олон нийтийг хамарсан хурал, зөвлөгөөн болон тусгайлсан мэргэжлийн сургалтад нийт 1350 оролцсон.

Сургамж, асуудал: Төслийн жилийн ажлын төлөвлөгөөг батлах ажил удаашралтай байснаас худалдан авах ажиллагаа 2022 оны 3 сараас эхэлж, гэрээ байгуулах үе шат төлөвлөсөн хугацаанаас оройтож хэрэгжсэн. Судалгааны ажил оройтож эхэлсэн хэдий ч төсөл хэрэгжүүлэгч нэгжээс гүйцэтгэгч талуудтай ажлаа нягт уялдуулж, судалгааны ажлыг аль болох богино хугацаанд хийх хуваарь гарган ажилласан. Орон нутгийн хамтын санхүүжилтийг шийдвэрлэх, талуудын оруулах хувь нэмэр тодорхой бус байсны улмаас төслийн 2022 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 2-р бүрэлдэхүүн хэсгийн гол ажлууд хэрэгжих боломжгүй байдалд хүрсэн тул төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарсан. Тиймээс Удирдах хорооны хурлыг 2022 оны 09 сарын 02-нд зохион байгуулагдаж, төслийн ажлын төлөвлөгөөг шинэчлэн баталгаажуулсан. Энэ хугацаанд 2022 онд 4 аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 8 сав газрын төлөвлөгөөнд нэмэлт судалгаа хийх зөвлөх үйлчилгээг шалгаруулах худалдан авах ажиллах тодорхой хугацаагаар хойшлогдсон. Мөн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахад хугацаа шаардсан, тендер оролцогчдын тоо хангалтгүй байсан зэрэг нь тодорхой нөлөө үзүүлсэн. Зарлагдсан ихэнх ажлууд нь техникийн өндөр ур чадвар шаардагддаг тул тендерийн үйл ажиллагаа давтан явагдсан. Ихэнх үйл ажиллагааны бодит хэрэгжилтийг 2022 оны есдүгээр сард эхлүүлсэн.

Бүрэлдэхүүн хэсэг 1:

Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд нийт 27 үйл ажиллагаа зохион байгуулахаас 19 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 8 ажил хэрэгжилтийн шатандаа гүйцэтгэлийн хувь 60 байна. Төслийн жилийн ажлын төлөвлөгөөг батлах ажил удаашралтай байснаас худалдан авах ажиллагаа 2022 оны 3 сараас эхэлж, гэрээ байгуулах үе шат төлөвлөсөн хугацаанаас оройтож хэрэгжсэн. Үүнтэй холбоотойгоор судалгааны ажлын хугацаа хоцорсон боловч ТХН гүйцэтгэгч компанитай ажлаа нягт уялдуулж, судалгааны ажлыг богино хугацаанд үр дүнтэй ажиллах талаас анхааран,

ажилласан. НРС худалдан авах бэлтгэл ажлыг 2022 онд хийсэн. Үүний үр дүнд НРС худалдан авах олон улсын тендерийг 2022 оны 12-р сарын 01-нд зарласан бөгөөд эцсийн хугацаа нь 2023 оны 11-р сарын 10-ны өдөр юм. ЦУОШГ-т дэмжлэг үзүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн улирлын болон урт хугацааны төсөөллийг тооцоолон гаргах чадавхыг дээшлүүлэх ажлын хүрээнд ЦУОШГ-ын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор ЦУОШГ-ын ахлах ажилтан, мэргэжилтнүүдэд зориулсан Орон нутгийн газрын системийн загвар /Community Earth System Model (CESM) болон NCAR хэл (NCL) зэрэг уур амьсгалын судалгаа хийх, урьдчилсан мэдээ боловсруулах (WRF) загвар, арга технологи, загвар ашиглах болон боловсруулалт хийх аргуудын талаар сургалт зохион байгуулсан. Уур амьсгалын эрсдэлийн мэдээлэлд суурилсан төлөвлөлт, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилан таамаглах (IBF), таамаглалд суурилсан санхүүжилт (FBF) зэрэг аргачлалуудыг боловсруулж байгаа бөгөөд 2023 оны 2-р улиралд эцэслэн шийдвэрлэхээр төлөвлөж байна. Төслийн хүрээнд 37 сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө, усны нөөцийн нэгдсэн менежментийн 8 төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ, дасан зохицох арга хэмжээг тусган шинэчлэн боловсруулж боловсруулж байна.

Бүрэлдэхүүн хэсэг 2:

Бүрэлдэхүүн хэсэг 2-ийн хүрээнд нийт 32 үйл ажиллагаа зохион байгуулахаас 19 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 13 ажил хэрэгжилтийн шатандаа гүйцэтгэлийн хувь 55 байна. Бүрэлдэхүүн хэсэг 2-ын зарим арга хэмжээг хэрэгжүүлэх суурь судалгаанууд бүрэн хийгдэж тус судалгаанд үндэслэн төсөл хэрэгжих хугацаанд хэрэгжүүлэх дасан зохицох арга хэмжээг зохион байгуулах сумуудыг тодорхойлсон. Энэ оны хувьд дасан зохицох арга хэмжээг зорилтод аймагт бүрд хэрэгжүүлж эхэлсэн нь хамгийн гол үр дүн байсан. Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор 6 булгийн шандын эхийг байгальд ээлтэй технологи ашиглан хамгаалж тохижуулсан бөгөөд зөвхөн булгийн эх ундарга төдийгүй, ойр орчны малын хөлд талхлагдсан талбайг нөхөн сэргээсэн. Төсөл хэрэгжиж аймгуудын одоо байгаа нөхөрлөлд суурилсан малчид, малчдын бүлгүүдийн оролцоотойгоор бэлчээр, ой, ус ашиглалтын менежментийн өнөөгийн туршлага, малчдын бүлгүүдийн мэдээллийн талаар суурь мэдээлэлтэй болсон.

Бүрэлдэхүүн хэсэг 3:

2022 онд тус бүрэлдэхүүний 19 үйл ажиллагаа зохион байгуулахаас 13 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 5 ажил хэрэгжилтийн шатандаа гүйцэтгэлийн хувь 50 байна. Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний чиглэлээр цаашид хамтран ажиллах, хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай мэдээллийн төрөл, хэмжээг тодорхойлохын тулд НҮБХХ-ийн “Тогтвортой ноолуур” платформын үйл

		<p>ажиллагаанд тогтмол оролцож, SFA буюу “Тогтвортой ноос, ноолуурын эвсэлтэй 1 удаа уулзалт зохион байгуулж, хувийн хэвшлийн төлөөлөл болох чиглэлээр Говь компани, Сор кашемир, Гоёл зэрэг байгууллагуудтай 4 удаагийн уулзалт зохион байгууллаа. Малчдын байгууллагуудын засаглалын чиглэлээр зөвлөх байгууллага төслийн 4 аймагт ажиллаж энэ чиглэлээр төсөл хэрэгжүүлэх нэгж суурь мэдээлэлтэй болсон. Гэрээний төслийг боловсруулахдаа холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлж, тухайн нөөцийг ашиглахад тулгарч байгаа гол бэрхшээлүүдийг шийдэхэд чиглүүлэн боловсруулсны гадна орон нутгийн холбогдох албан тушаалтан, малчдын төлөөллөөс санал авч, боломжтой саналуудыг тусгасан болно.</p> <p>Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон, гарал үүсэл нь тодорхой, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны байгууллагуудыг дэмжих, бүтээгдэхүүнд үнэ цэнэ /нэмүү өртөг/ шингээх, үндэсний болон олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх, хөдөөд ажлын байр нэмэгдүүлэх чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын эхлэлийг тавьж ажиллаж байна.</p>				
9.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Төслийн хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авалт, зөвлөх үйлчилгээний ажлуудыг зохион байгуулахад БОАЖЯ-наас үнэлгээний хороо, ажлын хэсгүүдийг цаг тухайд нь байгуулж, баталж дэмжлэг үзүүлсэн. Төслийн 2021 болон 2022 худалдан авах төлөвлөгөөний дагуу нийт 43 худалдан авалтын арга хэмжээг БОАЖЯ хариуцан эсвэл хамтрагч талуудад эрх шилжүүлэн хэрэгжүүлэхээс 36 (84%) арга хэмжээний худалдан авалтыг амжилттай гүйцэтгэсэн байна. Төслийн бусад хэрэгжүүлэгч хамтрагч талууд болох ХХААХҮЯ, ОБЕГ болон мэргэжлийн байгууллагууд нь төслийн 2022 оны төлөвлөгөөний төсөл, холбогдох ажлын даалгавруудад санал өгөх зэргээр хамтарч ажиллаж хувь нэмэр оруулсан. Төсөл хэрэгжих өнгөрсөн хугацаанд хамтын санхүүжилт, хариуцагч талуудын хариуцлага, оролцоо нь төслийн ажлын төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд нэн чухал байсан. Энэ онд төсөл хэрэгжиж буй дөрвөн аймгийн ЗДТГ-ыг төслийн хариуцагч тал болгон өөрчилж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай хамтран ажиллах гэрээ байгуулснаар тухайн орон нутагт гүйцэтгэх худалдан авалт, хариуцан гүйцэтгэх ажлын чанар, биелэлт, хяналтын тогтолцоогоо баталгаажуулсан. Төслийн жилийн төлөвлөгөөг батлуулахаас өмнө төслийн бүх оролцогч, хариуцагч талуудын үйл ажиллагааг төслийн баримт бичигтэй уялдуулах, арга хэмжээний талаар нэгдсэн нэг ойлголтод хүрэх нь нэн чухал учир холбогдох уулзалтуудыг хийх нь төслийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.</p>				
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Бүрэлдэхүүн хэсэг 1	Бүрэлдэхүүн хэсэг 2	Бүрэлдэхүүн хэсэг 3
		60,1%	3	61,5	61%	57,7 %
11.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				

12.	Жендэрийн мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - Төслийн 2022 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайланд жендерийн үйл ажиллагааны хэрэгжилтийн мэдээг нэгтэн боловсруулж, санхүүжүүлэгч байгууллага “Уур Амьсгалын Ногоон Сан”- д хүргүүлэв. - Жендэрийн хэвшмэл ойлголтыг устгах, олон нийтийг жендэрийн тэгш байдлын талаарх мэдээллээр хангах зорилгоор 2022 оны 2 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд баруун бүсийн байгаль орчны салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн “Олуулаа нэгдэж асуудлаа шийдье” сэдэвт уулзалтыг Дэлхийн байгаль хамгаалах сангийн баруун бүсийн салбартай хамтран зохион байгуулав. Уулзалтад 20–59 насны нийт 125 эмэгтэй ажилтан оролцов. - Төслийн “Байгаль орчин, Нийгмийн Менежментийн Хамрах Хүрээ”-г шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд “Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, Байгаль орчны салбарын жендерийн стратеги 2014- 2030, НҮБХХ-ийн Жендэрийн тэгш байдлын стратеги зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан шинэчилж байна. Ажил гүйцэтгэх хуваарийн дагуу шинэчилсэн төлөвлөгөөг 2023 оны 03-р сарын 06-ны өдөр хүлээн авна. - 2022 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар төслийн үйл ажиллагааны хүрээнд нийт 14 удаагийн олон нийтийг хамарсан хурал, зөвлөгөөн болон тусгайлсан мэргэжлийн сургалтыг зохион байгуулж оролцогчдын хүйсийн мэдээллийг цуглуулсан. Нийт 1345 оролцогчдын 42,3 хувь нь эмэгтэй, 57,7хувь нь эрэгтэй байна. Мөн, зохион байгуулагдсан сургалтад эмэгтэйчүүдийн оролцоо илүү буюу 57,1 хувийг эзэлж байгаа бол олон нийтийг хамарсан хурал зөвлөгөөнд эрэгтэйчүүд илүү оролцоотой буюу 59,1 хувийг эзэлж байна. - Төсөл хэрэгжих 4 аймгийн нийт 68 сумдаас уур амьсгалын сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэл маш өндөр 25 сумдын малчдын байгууллагуудад гэрээт гүйцэтгэгчийн ирүүлсэн зөвлөх үйлчилгээний судалгаанд үндэслэн жендэрийн дүн шинжилгээг хийсэн. Судалгаанаас 25 сумдад малчдын байгууллага нь нөхөрлөл/нөөц ашиглагчдын байгууллага (НАБ), хоршоо, бэлчээр ашиглагчдын холбоо (БАХ) хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хоршооны үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо хамгийн өндөр байна. Дорнод аймгийн Матад сум, Завхан аймгийн Улиастай суманд аль ч хэлбэрийн малчдын байгууллага бүртгэгдээгүй бол Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон, Халзан зэрэг сумдын малчдын байгууллагын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо байхгүй байна. - Зөвлөх үйлчилгээний хүрээнд Завхан, Ховд аймгуудад шинээр байгуулагдсан 113 малчдын байгууллагуудад
-----	--------------------	--

		<p>эмэгтэй удирдлагатай байгууллага 6.2%-ийг эзэлж байгаа нь эмэгтэйчүүдийн оролцоо бага байгааг илтгэж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Төсөл хэрэгжих аймгуудад жендэрийн хэвшмэл ойлголтыг устгах, малчин эмэгтэйчүүдийг дэмжих 60,000 ам.долларын төсөв бүхий 3 үйл ажиллагааг төслийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж Төслийн удирдах хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулав. - 2022 онд төслийн хүрээнд хийгдэж байгаа “Сумын хөгжлийн төлөвлөгөө” боловсруулах, Малчдын байгууллагын судалгаа, Малчдын амьдралын чанарт УАӨ-ийн нөлөөллийн судалгаа “Уламжлалт аргаар бэлтгэсэн сарлагийн борц, сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх нь” зэрэг нийт 11 зөвлөх үйлчилгээний ажлын тайлан, бодлогын баримт бичигт жендэрийг тусгав.
--	--	---

ХЯНАСАН:

ТӨСЛИЙН ҮНДЭСНИЙ ЗОХИЦУУЛАГЧ



Ю.БАЯРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН МЭДЛЭГИЙН МЕНЕЖМЕНТ,
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН



Г.БАЯРХҮҮ